

Улаанбаатар: ӨНӨӨДӨР

Өдөр -19
Шөнө -27

УЛС ТӨР

Я.СОДБААТАР: ДОТООДЫН ЦЭРГИЙГ СЭРГЭЭХ ШААРДЛАГАТАЙ ГЭЖ ҮЗСЭН

II нүүрт

ДЭЛХИЙ

ЕРДӨӨ НАЙМАН ХҮН Л ДЭЛХИЙН 3.6 ТЭРБУМ ХҮНЭЭС ИЛҮҮ ХӨРӨНГӨТЭЙ БАЙНА

IV нүүрт

Дугаарын **60** мөр

ҮЗЭЛ БОДОЛ

Хот нь харласан малчид нийслэл рүү хөдлөхийн цагт...

Н.НОРЖИН

ХӨШИГТӨД ОНГОЦ БУУЖ БОЛОХГҮЙ ГЭНЭ ҮҮ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Онцгой байдлын ерөнхий газрын мэдээллээр 17 аймгийн 127 суманд өвөлжилт хүндэрсэн хэдий ч малын тоо толгой хорогдсон тухай мэдээлэл бүртгэгдээгүй нь энэ цаг үед хамгийн сайн мэдээ. Гэвч цагаан зуднаас илүүтэй “цэцгэн” зуд нүүрлэж, хоттой хонь нь гуравхан хоногийн дотор хиарсан тухай нулимс унаган ярих малчинтай тааралдлаа. Тодруулбал, Төв аймгийн Борнуур сумын Наран багийн иргэн Б.Тэднийх хүний өөрийн нийлсэн 500 гаруй хонь хариулдаг байж. Харамсалтай нь хэдхэн хоногийн өмнө хоттой хонинд нь цэцэг өвчний шинж тэмдэг илэрч, сум, аймаг руу хэл хүргэх, сумын мал эмнэлэг нь вакцины эрэлд хатах зуур өвчин хотноос хотонд халдварлан газар авсан байна.

Үргэлжлэл нь III нүүрт

Н.ПУНЦАГБОЛД

Одоо нэгэнт Хөшигтийн хөндийд Олон улсын нисэх онгоцны буудал баригдаад, удахгүй улсын комисс хүлээж авах гэж байхад ийм юм яриад ч хэрэг байхгүй л дээ. Гэхдээ л илүү

үглэхгүй байж тэсэхгүй нь. 2006 онд одоогийн УИХ-ын дарга М.Энхболд Ерөнхий сайдаар ажиллаж байх үедээ Япон улсад айлчилсан Олон улсын нисэх онгоцны буудал барих асуудлыг ярьж, улмаар хөнгөлөлттэй зээлийг шийдвэрлэсэн байдаг. Дараа

жил нь тухай үеийн Ерөнхийлөгч Н.Энхбаяр Япон Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэрээ энэ асуудлыг хөндөж ярилцсан байдаг. Үүний дүнд “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл”-ийг хэрэгжүүлэх Япон Улсын Засгийн

газраас Монгол Улсын Засгийн газарт олгох “MON-P8” хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийг 2008 оны тавдугаар сарын 1-нд байгуулж, мөн сарын 29-ндөө УИХ-аар соёрхон батласан юм.

Үргэлжлэл нь III нүүрт

ДЭЛХИЙ

Д.ТРАМПЫГ ТАНГАРАГ ӨРГӨХ ҮЕЭР 18 МЯНГАН ЦАГДАА ХАМГААЛАЛТАД ГАРНА

Б.СУМЬЯА

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулж, тус улсын 45 дахь Ерөнхийлөгчөөр тодорсон үл хөдлөх хөрөнгийн

тэрбумтан Доналд Трамп ирэх баасан гарагт тангаргаа өргөнө. Ингэснээр Барак Обамагийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж, БНН АНУ-ын бодлого тодорхойлох бүхий л дээд

байгууллагад ноёрхох юм. Тэгвэл шинэ Ерөнхийлөгчийн тангаргаг өргөх ёслолын сургуулилт саяхан болжээ. Нийслэл Вашингтон ДС хотод байрлах Капитолын ордны их

хурлын танхимын өмнөх индэр дээр тангаргийн сургуулилт болж, цэргийнхэн оролцсон байна.

Үргэлжлэл нь IV нүүрт

ТОМИЛОЛТ

Хамтын зүтгэлээр эх нутгаа хөгжүүлэх сэлэнгэчүүд зорилтоо тодорхойллоо



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ДАВААХҮҮ

Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө “Хамтын зүтгэлээр эх нутгаа хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор боловсруулан ИТХ-аараа батлуулсан. Тэгвэл хөтөлбөрийн хэрэгжилтийн гарааны жилийн удирдах ажилтны анхдугаар зөвлөгөөн энэ сарын 12, 13-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж, 17 сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, орон нутгийн өмчит газрын дарга, захирлууд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцсон юм. Зөвлөгөөний эхэнд Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил илтгэл тавьсан бөгөөд аймгийн цаг үеийн нөхцөл байдал, Засаг даргаар томилогдсоноос хойшхи хугацаанд санаачилсан, хийж хэрэгжүүлсэн ажил, авсан арга хэмжээ, үр дүн, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж батлуулсан бодлогын баримт бичгүүд, цаашид хийхээр төлөвлөж буй ажлуудаа танилцуулж, 17 сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нар, сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, ОНӨААТҮГ-ын дарга, захирлуудтай хамтран ажиллах гэрээгээ батламжилсан. Сэлэнгэ аймгийн тухайд 2016-2017 оны өвөл, хавар 17 суманд 8773 малчин, мал бүхий өрхөд 1.6 сая мал өвөлжиж буй бөгөөд өнөөдрийн байдлаар өвөлжилт аймгийн хэмжээнд хүндрээгүй боловч цах ихтэй Зүүнбүрэн, Хушаат, Цагааннуур, Түшиг, Ерөө, Хүдэр, Баянгол, Орхон, Орхонтуул, Мандал, Баруунбүрэн, Шаамар сумдад мал бэлчээрлэхэд хүндрэл үүсч өвөлжилт хүндрэх төлөвтэй байгааг аймгийн Засаг дарга онцолсон.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

TISSOT
SWISS WATCHES SINCE 1853

ЭХНИЙ 10 ХҮНД
1.000.000₮ ХҮРТЭЛ ХУДАЛДАН АВАЛТАНД VICTORINOX БЭПЭГПӨНӨ

Хаяг: Хүүхдийн 100 Наран Молл: Утас-99073568
УИД-ийн баруун талд байрлах Наран Центр: Утас-99066813
www.facebook.com/swisswatchshopmongolia/

ХААН банк	Авах		Зарах		Хуудалгаа хөгжлийн банк	Авах		Зарах	
	АМ.ДОЛЛАР	ЕВРО	ИЕН	ЮАНЬ		АМ.ДОЛЛАР	ЕВРО	ИЕН	ЮАНЬ
	2490.00	2616.00	21.56	21.92		2490.00	2619.00	21.55	22.15
	2504.00	2680.00	21.92	21.92		2504.00	2691.00	22.15	22.15
	2951.00	40.10	359.00	359.00		2967.00	40.45	364.00	364.90
	3055.00	43.70	364.90	364.90		3048.00	44.18	364.90	364.90

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

Дархан хотноо 21 дэх уулзалт эхэллээ

Ардчилсан намын VI их хурлаас гарсан шийдвэрээр намын даргаа бүх гишүүдийнхээ саналаар тодруулахаар болж өдгөө нэр дэвшигчид монгол орноо нар зөв тойрон гишүүд дэмжигчидтэйгээ уулзаар байна. Өчигдөр Дархан-Уул аймагт 21 дэх уулзалт эхэлж байна. Намын даргын сонгуулийн хорооноос гаргасан журмын дагуу таван уулзалт бүрийн дараа мөрийн хөтөлбөр танилцуулах дарааллыг сугалаагаар тогтоож

байгаа юм байна. Энэ удаад Дархан хотод тав дахь сугалааг хийж С.Эрдэнэ, Д.Эрдэнэбат, Н.Алтанхуяг, Л.Гантөмөр, Ж.Батзандан гэсэн дарааллаар намынхаа нөхдөд мөрийн хөтөлбөр, үзэл бодлоо хүргэхээр болжээ. Ардчилсан намын даргын сонгуульд нэр дэвшигчдийн сурталчилгааны нэгдсэн уулзалт 4-5 цаг үргэлжилж, гишүүд санаа бодлоо илэрхийлэн, сонирхсон асуултауддаа хариулт авч байгаа юм.

ХААЛТАЙ ХУРАЛДААНААС



Я.СОДБААТАР: ДОТООДЫН ЦЭРГИЙГ СЭРГЭЭХ ШААРДЛАГАТАЙ ГЭЖ ҮЗСЭН

Гэрэл зураг Г.АРГУУЖИН

Ж.ОТГОН

УИХ дахь МАН-ын бүлэг хуралдаанаараа хэлэлцсэн асуудлын талаар УИХ-ын гишүүн Б.Саранчимэг, Я.Содбаатар, Г.Занданшатар нар сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Энэ удаагийн хуралдаанаар Засгийн газраас өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Дотоодын цэргийн тухай хуулийн төслийн талаарх ХЗДХ-ийн сайд С.Бямбаогтын мэдээллийг сонссон байна. Мөн Мал эрүүлжүүлэх авч хэрэгжүүлж байгаа бодлого арга хэмжээний талаар ХХАХУ-ийн сайд П.Сэргэлэнгийн мэдээлэл, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төсөл, Малын генетикийн нөөцийн тухай хуулийн төслийн танилцуулга мэдээллийг сонссон байна. Мөн Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн төслийг санаачлагч УИХ-ын гишүүн Г.Занданшатар танилцуулга хийжээ. Бүлгийн хурлаар уг хуулийн төслүүдийг хэлэлцээд шуурхай явуулах нь зүйтэй гэж санал нэгдсэн байна. Энэ талаар УИХ-ын гишүүн Я.Содбаатар “Дотоодын цэргийн тухай хуулийн төслийн хүрээнд цагдаагийн байгууллагын харьяанд дотоодын цэргийг байгуулахаар заасан юм. Улс орны чухал объектуудыг хамгаалах, мөн үймээн самуун гарахад цагдаагийн байгууллагын харьяанд дахь дотоодын цэрэг хамгаалж, хэв журам сахиулж ирсэн. Энэ тогтолцоо 1922 оноос эхтэй бөгөөд 1992 он хүртэл Нийгмийг аюулаас

хамгаалах яамны харьяанд, 1992 оноос 2014 он хүртэл цагдаагийн байгууллагын харьяанд зохицуулагдаж ирсэн юм. Өмнөх УИХ-аар холбогдох хуулийг шинэчлэн баталснаар 2014 оноос цагдаагийн байгууллагын харьяанд байсан дотоодын цэрэг татан буугдсан. Чиг үүргийг нь цагдаа харуцаж ирсэн. Холбогдох мэргэжлийн байгууллагуудын судалгаагаар дотоодын цэргийг сэргээх шаардлагатай гэж үзсэн, мөн улсын онц чухал объектууд дотоодын цэргээр хамгаалуулах нь эдийн засгийн талаасаа ч хэмнэлттэй. Иймээс УИХ дахь МАН-ын бүлэг дотоодын цэрэг байгуулахыг дэмжсэн” гэлээ. Мөн бүлгийн хуралдаанаар Засгийн газраас өргөн мэдүүлсэн Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төсөл, Малын генетикийн нөөцийн тухай хуулийн төслийн танилцуулга мэдээллийг хэлэлцээд дэмжжээ. Энэхүү хууль өмнөх парламентад хэлэлцэж байгаад анхны хэлэлцүүлгээсээ буцаж байсан юм. Энэ талаар УИХ-ын гишүүн Я.Содбаатар “Монголчууд бид сүүлийн үед хөдөө аж ахуйн салбараа хөгжүүлэх, энэ салбарын бараа бүтээгдэхүүнийг эцсийн байдлаар үйлдвэрлэдэг болохыг зорин ажиллаж байгаа. Мөн хөдөө аж ахуйн салбар тэр дундаа мал аж ахуйн салбарыг сэргээх, экспортыг нэмэгдүүлэх зэрэг олон асуудал энэ хуулийн хүрээнд яригдаж байгаа. Тиймээс шинэ Засгийн газар байгуулагдсан цагаасаа хойш мал эрүүлжүүлэх “Монгол мал” хөтөлбөрийг хүрээнд олон

талт арга хэмжээг дотооддоо төдийгүй гадны ОХУ, БНХАУ-тай хамтран хэрэгжүүлж байгаа. Энэ чиглэлд авч хэрэгжүүлж байгаа бодлого арга хэмжээний үр дүн болоод цаашид хийх олон талд арга хэмжээнүүд энэ хуулиуд гарсанаараа олон зүйлийг цэгцлэх боломж бүрднэ гэж ойлгож байгаа. Нэг үгээр хэлбэл, өнөөгийн мал аж ахуйн салбарт тулгамдаад байгаа асуудлын томоохон шийдэл болж чадах хуулийн төсөл гэж харж байгаа” гэсэн юм. Түүнчлэн бүлгээр УИХ-ын гишүүн Г.Занданшатар нарын санаачилсан Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн төслийг хэлэлцээд дэмжсэн байна. Шийдвэр гаргахад төвшинд иргэдийн оролцоог хангахад дээрх хууль чухал ач холбогдолтой хэмээн бүлэг үзжээ.

юм гэж үзэж байгаа. Улс орныг хамарсан, эмх замбараагүй байдал үүсэн үед дотоодын цэргийг оролцуулах нь чухал байгаа юм. Өмнө нь нийм зүйл гарч байсан. Олон орон энэ асуудлыг дотоодын цэргийн хүчээр шийдвэрлэж байсан. Зэвсэгт хүчин иргэдийн өмнөөс буу барьж болохгүй. Тиймээс энэ асуудал бол Монгол Улсын онцлогт тохирсон, шаардлагад нийцэж байна. Үүнийг халаад хоёр жил болж байна. Энэ салбарын мэргэжилтнүүдийн судалгаагаар дотоодын цэргийг сэргээх нь цаг үеийн шаардлагад нийцэж байна гэж үзэж холбогдох хуулиудыг Засгийн газар бүрэн барьсан.


АН-ын бүлгийн хурал цуцлагдлаа

УИХ дахь АН-ын бүлэг өчигдөр 10.00 цагт хуралдах ёстой байсан. Хурлаар Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн шалгалтын талаар, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслийг хэлэлцэх эрт төлөвлөсөн байна. Гэвч тус бүлгийн хурал цуцлагдсан. Учир нь УИХ-ын гишүүн Л.Болд, Б.Наранхүү нар гадаад томилолттой, УИХ-ын гишүүн С.Эрдэнэ, Ж.Батзандан, Д.Эрдэнэбат нар орон нутагт ажиллаж байгаа, УИХ-ын гишүүн Д.Муратын ар гэрт ажил явдал гарсан тул чөлөө авчээ. Ийнхүү бүлгийн зургаан гишүүн чөлөө авсан тул АН-ын бүлгийн хурал цуцлагдсан байна.

-2014 онд Хуульзүйн сайдаар УИХ-ын гишүүн асан Х.Тэмүүжинг ажиллаж байх үед Дотоодын цэргийг татан буулгасан. Одоо яагаад дахин сэргээж байгаа юм бэ?

УИХ-ын гишүүн Я.Содбаатар:

Дотоодын цэргийн чиг үүргийг Цагдаагийн Ерөнхий газрын харьяанд шилжүүлсэн байсан. Дотоодын цэрэг улсын чухал объектуудыг хамгаалдаг байсан. Өнөөдөр цагдаа гүйцэтгэж байна. Үүнийг цаашид дотоодын цэргүүдээр гүйцэтгүүлэх нь аюулгүй байдал талаасаа ч, санхүү талаасаа ч зөв



Гэрэл зураг Г.АРГУУЖИН

Н.НОМТОЙБАЯР сайг хэлмэгдсэн гэнэ

Өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын 21-нд Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгах, зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай Засгийн газрын тогтоол баталсан байна. Уг тогтоолоор “Монцемент биддинг материалс” ХХК-ийн 710, “Монголын алт” ХХК-ийн 1600 гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2017 онд ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн нь шүүмжлэл дагуулаад байгаа юм. Өөрөөр хэлбэл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярас өөрийнхөө компанийн ажиллах хүчийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн, эрх ашгийн зөрчилтэй тогтоол батлуулсан гэсэн үг. Тэгвэл энэ талаар тэрбээр “Импорт орлох үндэсний томоохон үйлдвэр аж ахуйн нэгжүүдийг Гадаадаас ажиллах хүч авах, гадаадад ажиллах хүч, мэргэжилтэн илгээх тухай хуулиар татвараас чөлөөлдөг зохицуулалттай. Энэ жил энэхүү зохицуулалтын хүрээнд 22 компани хамрагдаж байгаа. Түүнээс биш би өөртөө давуу байдал үүсгэж, хууль зөрчөөд хөнгөлөлт эдэлсэн асуудал байхгүй. Өмнө нь С.Чинзориг, Я.Санжмятав сайдын үед ч гардаг байсан тогтоол. Импорт орлох томоохон бүтээн байгууллагуудыг төр, засгийн зүгээс дэмжих энэ тогтоолыг баталдаг. Тухайн үйлдвэрүүд нь ашиглалтад орсноор ажлын байр нэмэгддэг, татвар төлдөг. Жилд 130 орчим орчим тэрбум төгрөгийн татвар төлдөг байгууллага шүү дээ” хэмээн тайлбарлаад байгаа. Үүнээс үзэхэд, энэ удаад Н.Номтойбаяр сайд хэлмэгдээд авсан бололтой.

МЭДЭЭЛЭЛ

“Төрийн гэрэг”-г сар шинээр гардуулна

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас нийгэм, эдийн засаг, оюун санааны ертөнцөд шинэ жишиг гаргаж, олон улсын стандартад хүрсэн, улс орныхоо өрсөлдөх чадварын нэрийн хуудас болж чадсан, бизнесийн шинэ чиглэлийн хөгжилд хувь нэмэр оруулсан дэд бүтэц, үйлдвэрлэлд “Үндэсний бүтээн байгуулалтын дээд шагнал-Төрийн гэрэг” шагналд олгодог. Мөн хөдөө аж ахуй, газар тариалан, аялал жуулчлалын салбарын үйлдвэрлэл, барилга байгууламж, улсын нэр хүндийг өргөсөн, өв соёл, үндэсний уламжлалыг сэргээсэн бүтээл туурвилыг шалгаруулж, жилд нэг удаа, билгийн тооллын он солигдохын өмнө уг шагналыг олгодог юм. “Үндэсний бүтээн байгуулалтын дээд шагнал Төрийн гэрэг” шагналд Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын Тамгын газар орон нутагтаа тухайн жилд бий болсон бүтээн байгуулалтыг, Төрийн яамд салбартаа тухайн жилд бий болсон бүтээн байгуулалтыг, иргэд, төрийн бус байгууллагууд дэмжиж буй бүтээн байгуулалтыг нэр дэвшүүлэх эрхтэй. Тиймээс холбогдох бичиг баримтыг Ерөнхийлөгчийн Тамгын газарт энэ сарын 25-ны өдрийн дотор ирүүлж болох аж. Уг шагналыг олгох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн бичвэр бүхий цомыг сар шинийн баярыг тохиолдуулан Ерөнхийлөгч зарлиг гарган Төрийн ёслол хүндэтгэлийн өргөөнд гардуулах юм байна. Шагналыг хүртсэн бүтээн байгуулалтыг бий болгох ажилд идэвх санаачилгатай оролцсон, гардан бүтээсэн, зохион байгуулсан хүмүүсийг төрийн алдар цол одон медальд тодорхойлж болох бөгөөд эдгээр шагналыг цом олгох ёслолтой хамтатган зохион байгуулж гардуулах ажээ.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

Ж.МӨНХБАТ: 580 сая евро бондын зээлийг төлөх гурван хувилбар байгаа

Ж.МЯГМАР

Манай улс ирэх гуравдугаар сард 580 сая евро бондын зээл төлөх учиртай. Гэтэл энэ мөнгө Засгийн газарт байхгүй. Тиймээс ч эрх баригчид олон улсаас мөнгө зээлж, энэ их өрийг төлнө гэсэн мэдээлэл байгаа. Гэсэн хэдий ч одоог болтол манай улсад хөнгөлөлттэй зээл өгөх таатай харцу өгсөн улс алга л байна. Энэ талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатаас тодрууллаа.

-Ирэх гуравдугаар сард 580 сая евро бондын зээл төлнө. Энэ зээлийг хэрхэн төлөх боломж байна вэ?

-Монголын эдийн засаг маш хүндрэлтэй байгаа. Бэлэн мөнгөний төлөлт хийхэд хүндхэн байгаа шүү дээ. Энэ өрийг төлөх гурван янзын хувилбар л байгаа. Нэгдүгээрт, бэлэн мөнгөө төлөх, хоёрдугаарт, ямар нэгэн байдлаар хойшлуулдаг. Гуравдугаарт, бол төлж чадахгүй гэдгээ албан ёсоор зарладаг. Мэдээж нэг болон гуравдугаар хувилбар Монгол Улсад хүндхэн гэдэг нь ойлгомжтой. Бэлэн мөнгөөр өрөө төлөхөд эдийн засаг дийлэх ачаалал нь дийлэх боломж нь хомс байгаа. Харин өрөө төлж чадахгүй гэдгээ зарлана гэдэг бол аливаа улс орны хувьд хамгийн хүнд нөхцөл байдал үүснэ. Тиймээс хоёрдугаар хувилбар нь өнөөдрийн Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлын хувьд хамгийн зөв хувилбар юм болов уу гэдгийг ярьж байгаа. Гэхдээ одоогоор эцсийн шийдэл гараагүй байна. Тун удахгүй ОУВС-ийн дарга нь ирж албан ёсны уулзалт хийнэ. Ингээд ОУВС-ийн хөтөлбөрийг хүлээж авах эсэх асуудлыг энэ сардаа багтаагаад эцсийн байдлаар шийдэх байх.

-Ер нь энэ 580 сая евро бондын зээлийг юунд зарцуулчихсан юм бэ?

-Саяхан та бүхэн Хөгжлийн банкны шалгалтын дүн болоод нөхцөл байдлыг ханраалалтай харж байгаа байх. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд төсөл хөтөлбөрүүдийг

санхүүжүүлсэн, зээл олгосон зэрэгт л зарцуулагдсан. Хөгжлийн банкны ажлын хэсгийн шалгалтын дүн УИХ-д танилцуулагдаж, хэвлэл мэдээлэл олон нийтэд нээлттэй болсон. Засгийн газар ажлын хэсгийн шалгалтын 200 орчим хуудас материалыг нууцын зэрэглэлээс гаргаад байгаа. Тиймээс бүх хүнд нээлттэйгээр хүрч байгаа.

-Тэгвэл үр дүнгүй зүйлд 580 сая евро бондын зээл зарцуулагдчихсан гэж ойлгож болох уу?

-Ер нь бондын мөнгө болоод Хөгжлийн банкны зээлийн асуудлууд бол нэлээд хууль зөрчсөн. Ноцтой но-той зүйл байна. Үр дүнгийн хувьд бол УИХ-аас ажлын хэсэгт байгуулаад нягталж байгаа. Бидний авсан мэдээллээр Хөгжлийн банк болоод яамтай холбоотой бонд болон зээлтэй холбоотой асуудлыг шалгах хууль хүчний байгууллагын ажлын хэсэг гаргаад явж байгаа. Тиймээс энэ асуудал энэхүү зэрэглэлд байгаа болно. Ер нь өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд энэ Хөгжлийн банкнд дээр хууль зөрчсөн, сахилга хариуцлага алдсан олон асуудал болсон байна. Энэ мэт байдал л өнөөдөр Монгол Улсыг эдийн засаг ийм болоод

байна. Өрөнд ороод эргээд тэр өрөө төлж чадахгүй хэмжээний нөхцөл байдал үүсээд байгаа.

-УИХ-ын дарга саяхан ОХУ болоод арабын орнуудаад айлчлаад ирсэн. Гэтэл ОХУ-аас зээл гутал “Авсан зээлээ юунд зарцуулах нь тодорхой бус байна. Тиймээс зээл өгч чадахгүй” гэсэн хариу өгсөн гээд байх юм?

-Ийм асуудал болсон гэдгийг мэдэхгүй байна. Хэвлэлүүдэд янз бүрээр яригдаж байгаа. Гэхдээ эдийн засгийн босгож ирэхийн тулд ямар нэгэн гадны хөрөнгө оруулалт, зээл тусламж, дэмжлэг хэрэгтэй байгаа. Тиймээс Засгийн газар өөр өөрсдийнхөө шугамаар чиглэл бүр дээр ажиллаж байна. Хөгжлийн банкны болоод Чингис бондын эргэн төлөлт, Хятадын ардын банкны зээл гээд нэлээд олон өрийн байдалд орсон улс оронг бид хүлээж авсан нь үнэн. Харин одоо асуудлаас гаргах талаар бид хөөцөлдөж л байна.

-Зээлээ төлөх асуудлаа хойшлуулах асуудал яригдаж эхэлчихсэн юм уу?

-Энэ асуудлыг ганцхан өдөр яриад шийдчихдэг юм биш. Олон удаагийн уулзалт, яриа хэлэлцээр болж байж шийдэгдэх байх.

ММ-ИНФО
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 90873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**
Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн **Н.ПУНЦАГБОЛД**


Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ



Гэрэл зурагч Г.АРГУУЖИН

ХӨШИГТӨД МОНГОЦ БУУЖ БОЛДОХГҮЙ ТӨННЭ ҮҮ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Ингэснээр манай улс Японоос 300 сая орчим ам.долларын хөнгөлөлттэй зээл авч, Олон улсын нисэх онгоцны буудал барьж эхэлсэн нь эдүгээ ашиглалтад ороход бэлэн болчихоод байна. Харин яагаад Хөшигтийн хөндийд барихаар сонгосон юм бол гэдэг нь бас сонин. Мэдээж онгоцны буудал барихад хамгийн тохиромжтой энэ тэр гээд баахан тодорхойлолт байгаа л дээ. Гэхдээ М.Энхболд дарга өөрийн тойрогтоо томоохон бүтээн байгуулалт хийж, барьцаа лавшруулсан алсын хараа ч байсан байж магадгүй. Гэхдээ Хөшигтийн хөндийд энэ том хэмжээний бүтээн байгуулалтыг хийсэн нь алсыг хараагүй хэрэг биш үү. Өнөөдөр бид Улаанбаатар хотын хүн амын нягтаршлыг бууруулах гэж янз бүрээр оролдож байгаа. Ерөөсөө аль 2006 оны үеэс л нийслэлийг нүүлгэх, шилжүүлэх тухай яриа гарч эхэлсэн. Гэвч одоо болтол ямар нэгэн зоригтой үйлдэл энэ улстөрчдөөс гараагүй байна. Тэрбитгий хэл Улаанбаатар хотоос холхон шиг томоохон бүтээн байгуулалт ч өрнүүлээгүй. Ганц хийж байгаа ажил нь Хөшигтийн хөндийн нисэх онгоцны буудал. Мэдээж энэ нисэх онгоцны буудал ашиглалтад орохоор хэдэн хүн ажлын байраар хангагдана. Тэр хүмүүс Сэргэлэн сумын төвд амьдрах уу. Эсвэл

Хөшигтийн хөндийд нэг бяцхан хот босох юм уу. Ямар ч байсан суурин газар бий болох нь л болно. Гэхдээ хоттой ойрхон газар гайгүй суурин газар бий болж чадах уу. Сайндаа л нэг гайгүйхэн сумын хэмжээний суурин босвол их юм. Цаашлаад Хөшигтийн хөндийд нисэх онгоцны буудлыг дагаад ядаж аялал жуулчлал ч хөгжих боломж хомс. Тэр хавьд үзээд байх юм байхгүй. Аягүй бол нисэх буудлын дарга, удирдах ажилтнууд нь Улаанбаатар хотоос ажилдаа явна даа. Ингээд л хотоос хүн гаргах зорилго бүтэхгүй тийшээ хандаад байгаа юм. Ядаж байхад шинэ нисэх онгоцны буудлын хавийн газруудыг нь манай төрийн томчууд хуваагаад авчихсан юм биш үү. Юун аялал жуулчлалын бизнес эрхлэх. Цаашлаад Хөшигтийн хөндий чинь онгоцны буудал барихад яг тохиромжтой газар байсан

уу. Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих Төслийн удирдагч Кимихиро Маэта гэдэг хүн “Салхины хувьд ямар ч асуудалгүй. Асуудал үүсэхэд арга хэмжээ авч болдог. Харин энд гурван жилийн хугацаанд ажиллахад үүл доошилж манан их буудал нь ажиглагдсан. Үзэгдэх орчин муу харагдахаас эхлээд нислэг үйлдэж буй нисэгчид хүндрэл үүсэх тал бий” хэмээн ярьсан байна билээ. Энэ асуудал яваандаа том болж босч ирэх вий дээ. Жаахан цаг агаарын сааталтай, бороо, цастай, үүлэрхэг өдөр онгоц бууж болохооргүй болчих юм биш биз. Уг нь эхнээсээ жаахан бодлоготой байсан бол нисэх онгоцны буудлаа Улаанбаатар хотоос арай холхон шиг барьчих хэрэгтэй байсан юм. Магадгүй нөгөө яриад байсан Хархориндоо ч юм уу. Дэд бүтцийнх нь асуудлыг шийдээд, хуучин цэвэрлэх байгууламжийг засч янзлаад, тэр орчмыг хөгжүүлээд, онгоцны буудлаа барьчих байсан юм. Тэгсэн бол ёстой нөгөө Дархан, Эрдэнэтийн дайны, түүнээс ч том суурин газар бий болох нөхцлийг бүрдүүлж өгөх байлаа. Уг нь Хархоринд Олон улсын нисэх онгоцны буудал барихад хамгийн тохиромжтой гэж судлаад, тогтоосон гэсэн мэдээлэл гарч л байсан. Дээрээс нь Хархорин орчимд аялал жуулчлалыг

...Одоо ч Хархорин жилээс жилд хөгжиж, дэвшиж байна. Эртний Хархорум хотын туурь, тэр үед байсан 64 баганат буддын сүмийн суурь илэрсэн. Цаашлаад маш олон чухал олдворууд оллоо байгаа. Тэр бүхнээ музейдээ тавиад үзүүлж байна. Мөн Монголын бурхан шашны хамгийн том төв болох Эрдэнэзуу хийд тэнд байна...
Хөгжүүлэхэд хамгийн өндөр боломжтой. Цагтаа дэлхийн нийслэл байсан түүхэн газраа бид жаахан тордож чадвал аялал жуулчлалын хамгийн том бүс нутаг болгож болно

шүү дээ. Одоо ч Хархорин жилээс жилд хөгжиж, дэвшиж байна. Эртний Хархорум хотын туурь, тэр үед байсан 64 баганат буддын сүмийн суурь илэрсэн. Цаашлаад маш олон чухал олдворууд оллоо байгаа. Тэр бүхнээ музейдээ тавиад үзүүлж байна. Мөн Монголын бурхан шашны хамгийн том төв болох Эрдэнэзуу хийд тэнд байна. Орхоны хөндийн дурсгалт газрууд ч бий. Ер нь юм бүхэн тэнд байна шүү дээ. Аялал жуулчлал хөгжих бүх боломж байгаа. Гагцхүү жаахан л дэд бүтэц, хөгжил, том бүтээн байгуулалт хэрэгтэй байгаа юм. Тэр том бүтээн байгуулалт нь нисэх онгоцны буудал байх байлаа. Хэрвээ тэгсэн бол дагаад маш олон бүтээн байгуулалт өрнөнө. Мөн томоохон суурин газар бий болж, хөгжсөнөөр Улаанбаатар хотод чихэлдчихсэн байгаа энэ олон хүнийг бага ч болов цөөлөх байлаа. Ядахын мууд нэг аймгийн хэмжээний хүн Улаанбаатараас гараад явчихвал энэ утаа униар жаахан ч болов буурна шүү дээ. Ийм л ач холбогдолтой бүтээн байгуулалт байлаа. Гэвч Улаанбаатараас холгүйхэн барьчихлаа. Одоо яая гэх вэ, хамгийн гол зорилго болох нийслэлийн хүн амыг цөөлөх ач холбогдолтой байгаасай л гэж залбирахаас, өөр яалтай ч билээ.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Гэрэл зурагч Г.АРГУУЖИН

“Илгээгээр Олон улсын нисэх онгоцны буудал барьж эхэлсэн нь эдүгээ ашиглалтад ороход бэлэн болчихоод байна. Харин яагаад Хөшигтийн хөндийд барихаар сонгосон юм бол гэдэг нь бас сонин. Мэдээж онгоцны буудал барихад хамгийн тохиромжтой энэ тэр гээд баахан тодорхойлолт байгаа л дээ. Гэхдээ М.Энхболд дарга өөрийн тойрогтоо томоохон бүтээн байгуулалт хийж, барьцаа лавшруулсан алсын хараа ч байсан байж магадгүй. Гэхдээ Хөшигтийн хөндийд энэ том хэмжээний бүтээн байгуулалтыг хийсэн нь алсыг хараагүй хэрэг биш үү. Өнөөдөр бид Улаанбаатар хотын хүн амын нягтаршлыг бууруулах гэж янз бүрээр оролдож байгаа. Ерөөсөө аль 2006 оны үеэс л нийслэлийг нүүлгэх, шилжүүлэх тухай яриа гарч эхэлсэн. Гэвч одоо болтол ямар нэгэн зоригтой үйлдэл энэ улстөрчдөөс гараагүй байна. Тэрбитгий хэл Улаанбаатар хотоос холхон шиг томоохон бүтээн байгуулалт ч өрнүүлээгүй. Ганц хийж байгаа ажил нь Хөшигтийн хөндийн нисэх онгоцны буудал. Мэдээж энэ нисэх онгоцны буудал ашиглалтад орохоор хэдэн хүн ажлын байраар хангагдана. Тэр хүмүүс Сэргэлэн сумын төвд амьдрах уу. Эсвэл

Дугаарын 60 мөр

Хот нь харласан малчид нийслэл рүү хөдлөхийн цагт...

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Аймгийн онцгой байдлын алба хорио цээр тогтоож, 24-ийн давааны ойр орчимд өвөлжих малчдын хонин сүргийг вакцинд хамруулж, шаардлагатай бүхий л арга хэмжээг авснаар өвчний тархалтыг зогсоож чадсан ч өвчний голомт хэмээн нэрлэгдэх малчин Б-гийн хот харлан 40 гаруй тооны ямаатай л үлджээ. Өөрөөр хэлбэл, тэдний хоттой хонийг устгалд оруулсан гэсэн үг. Ингэхдээ сумын удирдлагууд “Улсын эдийн засаг хямарсан учраас нөхөн төлбөр өгөхгүй” хэмээн төрийн өмнөөс лүндэн буулгаад одоогож. Хонинд тусдаг цэцэг өвчин зөвхөн Төв аймагт гараад байгаа юм биш. Ховд аймгийн Манхан суманд өнгөрсөн арванхоёрдугаар сарын эхээр анх илэрсэн энэ өвчний вирус эдүгээ говийн бүсэд дэгдчихээд байгаа. Хамгийн сүүлд өнгөрсөн долоо хоногт Булган аймагт гарсан. Вакцины хүрэлцээ хангалтгүйн улмаас тухайн хотонд өвчний шинж илэрсэн л бол өвдсөн өвдөөгүй гэж ялгалгүйгээр устгалд оруулахаас өөр аргагүй гэх тайлбарыг холбогдох албаны мэргэжилтнүүд өгөх юм билээ. Вирусыг газар авахуулахгүйн тулд устгалд оруулах нь зүй ёсны арга хэмжээ гэж үзэж болох ч цаг бусын

гайгаас болж амьжиргаанаасаа салсан малчин иргэндээ нөхөн олговор олгохгүй хэмээсэн нь ямар учиртай юм бол оо. Хот нь харласан малчин цаашид хэрхэн амьдрах вэ гэх тухайд Монголын төр арга хэмжээ авч ёстой санагдана. Нөгөөтэйгүүр, утаандаа дарлуулсан Улаанбаатарын иргэдийн лав 30 шахам хувь нь хотоо харлуулж орхисон малчид амьдрал хөөж, нийслэлд орж ирсэн байдаг. Ажилгүй, орлогогүй, амьдрах газаргүй тэд уулын оройгоор хуарагнан бууцгааж, гал гарч болох бүгдийг түлснээр эдүгээ та бид хорт утаагаар уушгиа хордуулан хахир өвлийн ард гарцгааж буй. Ирэх хавар хонин цэцэг өвчний улмаас хотоо харлуулсан хэдэн зуун өрх нийслэлийн зүг хөсөг хөдөлгөхийг одоогоор хэлж мэдэх юм алга. Гагцхүү яндангийнхаа тоог нэмэхгүй байя, мал бүхий иргэндээ нутагт нь тогтооё гэвэл тэдэнд нөхөн олговор олгохын зэрэгцээ малжуулах арга хэмжээг цаг алдалгүй явах явдал болгоё. Түүнчлэн аймаг, сумдын удирдлагууд отрын малчид яваад өнгөрсний дараа л өвчин дэгдээд байгаа талаар яриад байгаа. Тэгэхээр вакцингүй гээд хонин сүргээ устгах эс бөгөөс вакцинд хамруулах хоёрын аль нь эдийн засгийн хувьд өгөөжтэй вэ гэдгийг давхар бодолцоход гэмгүй л байх.

ДЭЛХИЙ

Киргизэд онгоц сүйрч, 37 хүн нас баржээ

Төв Азийн Киргизэд Туркийн ачаа тээврийн нисэх онгоц орон сууцны хороололд сүйрч, шатсаны улмаас 37 хүн нас баржээ. Киргизийн Онцгой байдлын яамнаас мэдэгдсэнээр Хонконгоос хөөрсөн Туркийн ачаа тээврийн Боинг 747 загварын нисэх онгоц очигдөр өглөө Киргиз улсын нийслэл Бишкек хотоос холгүй газарт осолдсон аж. Ослын газраас бэлтгэсэн дүрс бичлэгт сүйрсэн онгоцны их бие шатаж буй байдал дүрслэгдсэн байна. Онгоц орон сууцны хороололд сүйрсний улмаас 15 орон сууц нурж, энгийн оршин суугч, хүүхэд, нисэх багийн ажилтнууд гээд нийтдээ 37 хүн амь үрэгджээ. Хохирогчдын дунд зургаан хүүхэд байсан гэнэ. Онгоцны бүхээгт нисэх багийн дөрвөн гишүүн байсны нэг нь ослоос амьд гарсан байна. Түүнчлэн, Киргизийн Засгийн газраас мэдэгдсэнээр ачааны онгоц Хонконгоос Туркийн Истанбул хотыг чиглэн нисч явсан бөгөөд шатахуун дууссаны улмаас Бишкект байрлах Олон улсын нисэх онгоцны буудалд газардахаар явахдаа ийнхүү сүйрчээ. Осол болох үед цаг агаарын нөхцөл байдал ч тааламжгүй байсан гэнэ. Тиймээс ослын шалтгааныг албаныхан цаг агаартай холбоотой байж магадгүй хэмээн үзэж, хяналт шалгалтын ажлыг эхлүүлжээ. Түүнчлэн, зарим эх сурвалж нисгэгч алдаа гаргасан байж болзошгүй талаар ч мэдээлж байгаа юм.



Д.ТРАМП ТАМГАРАГ ӨРГӨХ ҮЕЭР 18 МЯНГАН ЦАГДАА ХАМГААЛАЛТАД ГАРНА

Үргэлжлэл.
Түүрч нь I нүүрт

Сургуулийн үеэр Ерөнхийлөгч Доналд Трамп, дэд Ерөнхийлөгч Майкл Пенс нартай гадаад төрхөөрөө тун ижил эрхмүүд тэдний үүргийг гүйцэтгэн баруунгараа өргөн тангараг өргөж, тус ёслолын үйл ажиллагааны журам, зарцуулагдах хугацааг нарийн тооцон баталжээ. АНУ-ын шинэ Ерөнхийлөгчийн тангаргаа өргөх ёслолын үйл ажиллагааны үеэр Капитолоос Цагаан ордон хүртэлх автозамд зохицуулалт хийж, парад алхах гэнэ. Энэхүү үйл ажиллагаанд 700-900 мянган хүн оролцоно гэсэн тооцоо гарчээ. Гэвч эсрэгээр 100 гаруй байгууллага жагсаал зохион байгуулахаар төлөвлөсөн учир 28 мянган цагдаа цэргийн алба хаагч бэлэн байдалд ажиллах юм байна. Түүнчлэн, Трампын тангараг өргөх

ёслол сонгуулийн сурталчилгааны үеэр дэвшүүлсэн "Америкийг дахин аугаа гүрэн болгоно" гэх уриан дор зохион байгуулагдах аж. Үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Ерөнхийлөгчийн хувьд өмнө нь сонгуульд ялж байсан туршлагагүй учир тангараг өргөх ёслолын өмнөх өдөр Цагаан ордны өмнөх Блейр хауст ирж хонох юм байна. Улмаар ёслолын өглөө хамгийн түрүүнд сүмийн мөргөлд оролцож, дараа нь эхнэр Мелани Трампын хамт Цагаан ордонд зочилж, Барак Обамагийн гэр бүлтэй хамтдаа цай ууж цагийг өнгөрүүлснийхээ дараа тангараг өргөх ёслол болох Капитолын ордын их хурлын танхим руу явах ажээ. Ёслолын үйл ажиллагаа энэ сарын 20-ны өдрийн 11:30 цагаас эхэлж, Майкл Пенс дэд Ерөнхийлөгчийн тангараг өргөсний дараа Доналд Трамп Ерөнхийлөгчийн тангаргаа

өргөх юм байна. Ийн ёслолын үйл ажиллагааг зохион байгуулсны дараа Доналд Трамп албан ёсоор АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгч болж, бүрэн эрхийнх нь хугацаа эхэлнэ. Түүнчлэн, бизнесмэн эр илтгэл тавих бөгөөд энэ үеэр сонгуулийн кампанитын үеэр гүн гүнзгий хуваагдсан ард түмнээ дахин нэгдэхийг уриалах төлөвтэй байгааг ажиглагчид онцолж байгаа юм. Үүний дараа Барак Обама Ерөнхийлөгчийн хэрэглээний нисдэг тэргээр ёслолын үйл ажиллагааг орхино. Улмаар Капитолын ордонд шинэ Ерөнхийлөгч, тэргүүн хатагтай нарыг урьж, төр засгийн өндөр албан тушаалтнуудын хамт үдийн зоог барьсны дараа Д.Трамп гэргийнхээ хамт Цагаан ордон хүртэл парадар явах гэнэ. Шинэхэн Ерөнхийлөгчийн суусан машины цуваа болон 8000 орчим урлаг, соёлынхны парад Цагаан ордон хүртэлх тусгайлан

зохицуулалт хийсэн замаар үргэлжлэх ажээ. Найман жилийн өмнө Барак Обама тангаргаа өргөх үед парад гурван цаг орчим үргэлжилж байсан бол Трамп нэн даруй үүрэгт албандаа томилогдож, зорилго зорилтоо хэрэгжүүлж эхлэхийг хүсч буй учраас хугацааг богиносгож, парад цаг гаруй хугацаанд л үргэлжлэх юм байна. Түүнчлэн, ёслолд үе үеийн Ерөнхийлөгчид бараг бүгд оролцохоо илэрхийлсэн бол конгрессын доод танхимын Ардчилсан намын зарим гишүүн оролцох боломжгүй гэгдээ илэрхийлсэн байгаа юм. Хамгийн анхаарал татсан нэг асуудал нь ёслолын үеэр Трампыг дэмжигч болон эсэргүүцэгч гэсэн 100 гаруй байгууллага жагсаал хийхээр төлөвлөсөн явдал юм. Улмаар энэ үеэр мөргөлдөөн гарахаас сэргийлэх зорилгоор 28 мянган цагдаагийн алба хаагч бэлэн байдалд ажиллах ажээ.

Самсунг группын дэд Ерөнхийлөгч баривчлагдаж магадгүй



БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хетэй олон жилийн турш дотно нөхөрлөсөн Чой Сун Шил гэгч найзын харилцаагаа ашиглан тус улсын томоохон корпорациудад дарамт үзүүлэн хандив нэрийдлээр их хэмжээний мөнгийг өөрийн сандаа төвлөрүүлж байсан нь ил болсон билээ. Тэгвэл тус дуулиан дэгдсэнээс хойш Соүлд томоохон хэмжээний эсэргүүцлийн жагсаал долоо хоног бүр зохион байгуулагдах болсны зэрэгцээ парламентын гишүүд Ерөнхийлөгчид итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хураалт явуулж, ихэнх нь эсрэг сонголт хийж, Пак Гын Хе суудлаасаа буухыг дэмжсэн. Эдүгээ Үндсэн хуулийн шүүх 180 хоногийн дотор уг асуудлыг хянан хэлэлцэж, өнөөгийн Ерөнхийлөгч бүрэн эрхийн хугацаагаа дуусгах эсэхийг шийдвэрлэх учиртай. Тэгвэл Чой Сун Шилийн тойрсон авлигын хэргийг мөрдөн шалгаж буй тусгай ажлын хэсэг очигдөр Самсунг группийн дэд Ерөнхийлөгчийг хээл хахуулийн хэргээр баривчлах зөвшөөрөл олгохыг шаарджээ. Тэдний хувьд Чой Сун Шилийн урлаг, спортын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг санд

хамгийн их буюу 43 тэрбум вонг хандив нэрээр авлига өгсөн гэх үндэслэлээр Самсунг Электроникс компанийн дэд Ерөнхийлөгч И Чэ Юныг буруутгаж буй аж. Улмаар авлига, албан тушаалын хэргээр түүнийг баривчлах зөвшөөрөл олгохыг шүүхийн байгууллагаас шаарджээ. Прокуроруудын үзэж буйгаар, И дэд Ерөнхийлөгч аль эртнээс өөрийн эрх мэдлээ бататгахын тулд Самсунг группын салбар хоёр компанийг нэгтгэхэд хамтран ажиллахыг Ерөнхийлөгчийн тамгын газраас хүсч, Чой Сун Шилд авлига өгсөн гэнэ. Харин зарим орон нутгийн хэвлэлүүд Самсунг электрониксын дэд Ерөнхийлөгч гадаад улс орон руу оргон зайлах боломжгүй, хэрэв баривчилбал эдийн засаг хүндэрч болзошгүй гэх зэргээр бичиж байна. Ямартай ч, маргааш дэд Ерөнхийлөгч И Шүүх танхимд мэдүүлэх өгөх бөгөөд энэ үеэр баривчлах эсэхийг шийдвэрлэх гэнэ. Түүнчлэн, Самсунг электроникс компанийн дэд Ерөнхийлөгчийг баривчилж магадгүй гэх мэдээлэл гарсны дараа БНСУ-ын хувьцааны зах зээл дэх тус компанийн хувьцаа унаж эхэлжээ.

Хятадад шувууны ханиадаар хүн нас баржээ

Хятадын Хэнань мужид шувууны ханиадны вирусээр хүн нас барсан тохиолдол бүртгэгджээ. Хэнань мужийн Эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн зөвлөл 36 настай эрэгтэй хүн нас барсныг бүртгэсэн тухай мэдээллийг нэгдүгээр сарын 14-ны өдөр Синьхуа агентлаг мэдээлсэн

байна. Нас барсан эрэгтэй Жэянь хотод шарсан нугасны худалдагчаар ажилладаг байжээ. Тэрээр энэ оны нэгдүгээр сарын эхээр Юнчэн хотод байдаг гэртээ очжээ. Хэсэг хугацааны дараа Сужоугийн эмнэлэгт үзүүлэхээр очихдоо нас баржээ. Одоогийн байдлаар талийгаачтай

харьцаж, холбоотой байсан 16 хүнийг эмнэлгийн хяналтад аваад байна. Шувууны томуу өвчин хүнд халдварласан анхны тохиолдол 1997 онд Хонг-Гонгт бүртгэгдэж байсан бол хамгийн сүүлд энэ өвчний тохиолдол 2014 онд Канад улсад бүртгэгдэж байсан юм.

Ердөө найман хүн л дэлхийн 3.6 тэрбум хүнээс илүү хөрөнгөтэй байна

Дэлхийн хамгийн баян найман хүн дэлхийн 3.6 тэрбум хүнээс илүү их хөрөнгөтэй гэж олон улсын буяны байгууллагуудын холбоо "Oxfam" мэдэгдлээ. Тус байгууллагын мэдэгдэлд "Бид нарийвчилсан мэдээлэлд тулгуурлан энэ тооцоог гаргасан. Баян, ядуугийн ялгаа бодож байснаас илүү их зөрүүтэй байна" гэжээ. Давос хотод Дэлхийн эдийн засгийн форум эхлэх гэж байгаатай холбогдуулан "Oxfam" судалгааны тайлангаа танилцуулсан байна. "Oxfam" байгууллага өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд дээрхтэй адил тайлан гаргаж байсан юм. Тус байгууллагын 2016 оны тайланд "Дэлхийн хамгийн баян 62 хүн дэлхийн нийт хүн амын тал хувиас илүү баян байна" гэсэн байв. Энэ тоо 2017 онд ердөө найм болж буурчээ. "Oxfam" тайлбарлахдаа "Энэ оны тайланг илүү баттай, үнэн зөв мэдээлэлд тулгуурлан гаргасан" гэжээ. Өөрөөр хэлбэл, дэлхийн

хүн амын нэг хувийг эзлэх баячууд нь бусад бүх хүний хөрөнгийг нийлүүлснээс илүү их хөрөнгө чинээтэй байна.

Дэлхийн хамгийн баян найман хүний зарим нь хэдэн арван тэрбум долларыг сайн үйлст зарцуулж байгаа юм. Тухайлбал, Билл Гейтс эхнэр Мелиндагийн хамт ядууст туслах зорилгоор 44 тэрбум долларын хөрөнгө бүхий нэгэн санг 2000 онд байгуулсан билээ.

Мөн Марк Цукерберг болон түүний эхнэр Присила Чан нар 2015 онд "Бид нийт хөрөнгийнхөө 99 хувийг буяны үйлст хандивлана" гэж мэдэгдсэн юм. Үүнийг "Facebook"-ийн хувьцааны тухайн үеийн ханшаар үнэлбэл 45 тэрбум доллартай тэнцэж байна.



ДЭЛХИЙН ХАМГИЙН БАЯН НАЙМАН ТЭРБУМТАН

Билл Гейтс (АНУ):

"Microsoft" компанийг хамтран үүсгэн байгуулагч (75 тэрбум ам.долларын хөрөнгөтэй)

Уоррен Баффет (АНУ):

"Berkshire Hathaway" компанийн хамгийн том хувьцаа эзэмшигч нь (60.8 тэрбум ам.доллар)

Карлос Слим Хелу (Мексик):

"Grupo Carso" компанийн эзэн (50 тэрбум ам.доллар)

Жефф Безос (АНУ):

"Амазон" компанийг үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал (45.2 тэрбум ам.доллар)

Марк Цукерберг (АНУ):

"Facebook" компанийг үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал (44.6 тэрбум ам.доллар)

Ларри Эллисон (АНУ):

"Oracle" компанийг үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал (43.6 тэрбум ам.доллар)

Майкл Блумберг (АНУ):

"Bloomberg LP" компанийн эзэн (40 тэрбум ам.доллар)

МЭДЭЭЛЭЛ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Б.ЗАЯА

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн туслаачааны төвийн захирал Т.Уранболортой арилцлаа.

“Юун түрүүнд байгуулла- гынхаа чиг үүргийн талаар ярихгүй юу. Ер нь Хууль зүйн туслаачааны төв ямар үүрэгтэй ажилладаг юм бэ?”
-Манай байгууллага Монгол

замаар хууль зүйн туслаачаа авах, шүүхийн өмнө эрх тэгш байх, хүний эрхийг хангах зорилготойгоор нийслэлийн найман дүүрэг, 21 аймаг, хоёр сумдад нийт 31 салбарт 59 улсын өмгөөлөгчтэйгээр ажилладаг. Өмгөөлөгчийн туслах эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагчид өмгөөллийн болон хууль зүйн зөвлөгөөг үнэ төлбөргүй үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Танай төвийн талаар иргэд, хэр мэдээлэлтэй байдаг вэ.

өссөн үзүүлэлттэй байгаа. Энэ тоон мэдээг харахад, эдийн засгийн хүндрэлтэй байдлаас амьжиргааны баталгаажих төвшнээс доогуур орлоготой иргэдийн тоо өсөх хандлагатай байна. 2016 оны жилийн эцсийн тайлангаас харахад, иргэд манай төвийн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар илүү их мэдээлэлтэй болсон байна. Тухайлбал, нийт хууль зүйн туслаачаа хүссэн 2600 орчим өргөдлийн 1009 нь үйлчлүүлэгч болон түүний төлөөллийн хүнээс, 668 нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокуророос,

22345 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 7261 хэргийн 8393 холбогдогчид өмгөөллийн үйлчилгээ үзүүллээ. Дээрх тоон мэдээнээс манай байгууллагын эрэлт хэрэгцээ их байгааг харж болох байх.

“Иргэн, захиргааны хэрэгт яагаад ордоггүй юм бэ?”


-Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслаачааны тухай хуульд зөвхөн



Т.УРАНБОЛОР: ЗОРИЛТОТ БҮЛЭГТ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХЭД АНХААРЧ АЖИЛЛАНА

Улсын Үндсэн хууль, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжид заасан хүний эрхийг хамгаалах, шударга шүүхээр шүүгдэх, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхийг хангах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа гэдэг утгаараа иргэдийн өмгөөллийн үйлчилгээ авах эрхийг ханган, иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийг түргэн шуурхай хүлээн авч шийдвэрлэдэг. Мөн байгууллагынхаа үйл ажиллагааны талаар иргэд, олон нийт, хуулийн байгууллагад сурталчлан таниулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хууль зүйн туслаачааны төв нь хууль зүйн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах



Иргэдийн дунд үнэ төлбөргүй хууль зүйн туслаачаа авах эрэлт хэрэгцээ их байгааг харгаддаг?

-Манай байгууллагын жилийн эцсийн тайлан, мэдээнээс харахад, үнэ төлбөргүй хууль зүйн туслаачаа авсан үйлчлүүлэгчийн тоо жил тутам

504 нь шүүхээс ирсэн байна. Төвийн үйл ажиллагааг сурталчилж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 13838 иргэнд хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. 2014 онд байгуулагдсанаас хойш гурван жилийн хугацаанд нийт

эрүүгийн хэргийн холбогдсон сэжигтэн, яллагдагчид хууль зүйн туслаачаа үзүүлэхээр заасан байдаг. Иймд улсын өмгөөлөгч нь эрүүгийн хэргийн хохирогч, иргэн, захиргааны хэрэг, маргаанд оролцох боломжгүй байгаа юм. Гэхдээ иргэн, захиргааны хэрэг маргаан, эрүүгийн хэргийн хохирогчид улсын өмгөөлөгчөөс үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авах эрэлт хэрэгцээ байдаг нь иргэдээс манай байгууллагад хандан гаргасан өргөдөл, хүсэлт болон зорьж ирдэг иргэд нэлээд өндөр хувийг эзэлж байгаа. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслаачааны тухай хуульд 2017 онд шинэчилсэн найруулга оруулах талаарх суурь судалгаа хийгдэж эхлээд байна.

“Албан байгууллага болгон өнгөрсөн оны ажлаа дүгнэж, ирэх онд хийх ажлын төлөвлөгөөгөө боловсруулсан байгаа шүү дээ. Хууль зүйн туслаачааны төв 2017 онд өдөр тутмын үйл ажиллагаанаас гадна ямар асуудалд анхаарч ажиллах вэ?”

-2017 оныг Хууль зүй, дотоод хэргийн салбар бүхэлдээ иргэдэд ойр, эрх зүйн үйлчилгээний жил болгон зарласан. Энэ хүрээнд ХЗДХЯ иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг шинээр зохион байгуулж, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч, орон нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа дээшлүүлж, эдийн засаг бизнесийн орчинд үзүүлэх

хууль зүйн албаны үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргахаар зорьж байгаа билээ. Хууль зүйн туслаачааны төвийн үйл ажиллагаа бол иргэдтэй хамгийн ойр хэрэгцээтэй үйлчилгээ тул цаашид байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийг өргөжүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байгаа. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслаачаа үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэхээр тусгасан билээ. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд 2017 анхаарч ажиллаж, шаардлагатай тооцоо судалгааг чанартай хийж оновчтой хөтөлбөр саналыг боловсруулан ажиллах нь нэн тэргүүний зорилт болоод байна.



Аймагас мэдээлж байна

ГОВЬСҮМБЭР АЙМАГ



Татварын хэлтэс төлөвлөгөөгөө давуулан биелүүлэв

Говьсүмбэр аймгийн Татварын хэлтэс нь 2016 онд улсын төсөвт 2.5 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласанаас гүйцэтгэлээр 2.6 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 103.7 хувиар, орон нутгийн төсөвт 5.1 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээс 5.5 тэрбум төгрөг төвлөрүүлж 107.8 хувиар тус тус давуулан биелүүлж, орон нутгийн байгууллагуудын хэвийн ажиллах нөхцөл бололцоог бүрэн ханган ажиллажээ. Түүнээс гадна, тус хэлтэс 2017 онд байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, хэрэглэгчийн болон хөндлөнгүйн үнэлгээ хийлгэх, авлигын эсрэг үйл ажиллагааг ТББ-тай хамтран зохион байгуулах, албан хаагчдын ёс зүй, харилцааны талаар судалгаа хийлгэх, Татварын хууль тогтоомжийн талаар сургалт мэдээлэл сурталчилгааг хамтран хийх зэрэг үүднээс Хөгжлийн түншлэл ТББ, Хотол Чойр иргэний нийгмийн сүлжээ, ОНОШ ТБ, Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Жанжин Чойрын Данжин Сахнус ТББ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна.

ДАРХАН-УУЛ АЙМАГ

“Цагаан сар 2017” үзэсгэлэн худалдаа гарна

Дархан-Уул аймагт үндэсний уламжлалт сар шинийн баярыг утган “Үндэсний бүтээгдэхүүний хэрэглээгээ” уриан дор “Цагаан сар-2017” үзэсгэлэн худалдаа 19 дэх жилдээ зохион байгуулагдахаар болжээ. Үзэсгэлэн худалдаа ирэх сарын 15-19-ний өдрүүдэд “Залуучууд” театрт зохион байгуулагдах бөгөөд Ерөнхий зохион байгуулагчаар Аймгийн Эмэгтэйчүүдийн Холбоо, МҮХАУ-ын Дархан-Уул аймаг дахь салбар танхим ажиллах аж. Харин хамтран зохион байгуулагчаар аймаг, сумын ЗДТГ, Хүнс хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжилзүйн хэлтэс, Мэдээлэл технологийн алба, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс ажиллах юм байна. Үзэсгэлэн худалдааг аймгийн нийт үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг олон нийтэд таниулах, тэдний үйл ажиллагааг сурталчлахаас



гадна иргэдийг сар шинийн баярт зориулсан хүнсний бүтээгдэхүүн, хувцас хэрэглэлийг өргөн сонголттойгоор нэг дороос худалдан авах нөхцөл боломжоор хангах зорилгоор зохион байгуулж буй аж. “Цагаан сар-2017” үзэсгэлэн худалдаанд оролцох ААНБ, иргэдийн мэдүүлгийг өчигдрөөс эхлэн аймгийн Эмэгтэйчүүдийн холбооны байранд авч эхэлсэн бөгөөд ирэх сарын 13-ныг хүртэл үргэлжилнэ.

Үзэсгэлэн худалдаанд өндөр градусын архи согтууруулах ундааны үйлдвэрлэл худалдаа эрхлэгчид эбусад бүх хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэд чөлөөтэй оролцож болох юм байна. Хураамжийн хувьд компани өдрийн 50.000 төгрөг төлөх бол, жижиг дунд үйлдвэрлэгчид, хоршоо 25.000 төгрөг, өрхийн үйлдвэрлэгч иргэн 10.000 төгрөгний хураамж төлөх гэнэ.

ОРХОН АЙМАГ

Хотын агаарын бохирдлын талаар бодит дүгнэлт гаргахыг үүрэгдэв

Орхон аймгийн Засаг даргын шуурхай хуралдааны үеэр Засаг даргын орлогч А.Түвшинжаргал хотын утааны талаар бодит дүгнэлт гаргах үүргийг холбогдох байгууллагуудад өглөө. Тэрбээр “Өндөрлөг газраас хотын утаа харанхуйлж харагддаг. Гэтэл шинжилгээний дүнг харахад утаа буурсан ч юм шиг ойлгохоор байна. Тиймээс Байгаль орчин, аялал жуулчлалын газар, УЦУОША зэрэг байгууллагууд хамтраад хотын утааны талаар бодит дүгнэлт гаргаж иргэдэд

ХЭНТИЙ АЙМАГ

Зарим сумын эмнэлэгт түргэн тусламжийн автомашин гардуулав

Монгол Улсын Шадар сайд, улсын онцгой комиссын дарга У.Хүрэлсүхээр ахлуулсан ажлын хэсэг өчигдрөөс гурав хоногийн хугацаатай Хэнтий аймагт ажиллаж байна. Тэрбээр хүрэлцэн ирсэн даруйдаа

мэдээлэх хэрэгтэй байна” гэсэн юм. Түүнчлэн аймгийн БОАЖГ-аас хотын утааг бууруулах чиглэлээр хийж буй ажлаа энэ үеэр танилцуулла. Тодруулбал, Эрдэнэт хотын гэр хорооллыг бүсчлэн хувааж, дагаж мөрдөх журмыг мөрдүүлж эхэлсэн.

Мөн 2012 оноос сайжруулсан зуухыг 70 хувийн хөнгөлөлттэй үнээр олгох ажлыг зохион байгуулсан. Энэ хугацаанд буюу 2012 онд 1345, 2014 онд 1540, 2015 онд 1065 ширхэг сайжруулсан зуух олгожээ. Тэгвэл энэ онд 1500 ширхэг

сайжруулсан зуух олгож байгаа юм. Уг ажилд нийтдээ 500 сая төгрөг зарцуулж байна. Түүнээс гадна хөнгөлөлттэй цахилгаан халаалт, хийн зуух болон хоёр тарифт тоолуур 2200 гаруйг суурилуулах ажлыг үргэлжлүүлж байгаа талаар БОАЖГ-ын дарга С.Жаргалсайхан хэллээ. Мөн төр захиргааны байгууллагын бодлогын хүрээнд өрхийн хэрэгцээнд “Нако” түлшний нэвтрүүлсэн нь үр дүнгээ өгч байгаа гэж олон нийт үзэж байна. Тухайн түлшний нийлүүлснээр утааг буурсан

төдийгүй түлшний үнэ буурахад эерэг нөлөө үзүүлжээ. Үүнээс гадна мэргэжлийн байгууллагуудаас агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгааг явуулсан бөгөөд судалгааны дүнд аймгийн хэмжээнд 13190 орчим гал түлдэг суурин эх үүсвэр бүртгэгдсэн байна. Үүнээс гэрийн ердийн зуух 4253, гэрийн сайжруулсан зуух 468, байшингийн сайжруулсан зуух 1417, ханан пишин 6403, нам даралтын зуух 164 байгааг тогтоожээ.

Дадал, Баян-Адарга, Баянмөнх сумдын Эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн автомашин гардуулла. Мөн бусад өвөлжилт хүндэрсэн сумдад тусламжийн өвс тэжээл, эд зүйлийг хүргэхээр

Норовлин, Баян-Адрага, Дадал, Бэрх, Батноров сумдыг зорилоо. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ХХААХҮ-ийн дэд сайд Ж.Сауле, УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, НҮБ-ын хүмүүнлэгийн тусламжийн

зохицуулалт хариуцсан зөвлөх Жэсс гарана, Мерсикор ОУБ-ын Монгол дахь салбарын хөтөлбөрийн газрынхан Г.Энхцэцэг тэргүүтэй хүмүүс багтаж байгаа юм.

УРИЛГА

БНХАУ-ЫН ТЯНЬЖИН БООМТЫН ДУНЗЯНЫ ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ БООМТ БҮСЭД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН ТӨСӨЛД ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын “Далайд гарах боломжийг нэмэгдүүлэх талаар авч зарим арга хэмжээний тухай” 2013 оны 152 дугаар тогтоолын хүрээнд БНХАУ-ын Тяньжин хотын Дунзан чөлөөт худалдааны боомт бүсийн 10 га газарт Хятадын талтай хамтарсан компани байгуулж “Тээвэр ложистикийн төв” төслийг хэрэгжүүлэх, энэхүү төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах боломж бүхий дотоодын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг хамтран ажиллахыг урьж байна.

Санал ирүүлэх компаниудад тавигдах шаардлага

- Компани татварын өргүй;
- Санхүүгийн чадамжтай;

“Тогтвортой, удаан хугацаанд хамтран ажиллах.

Санал авах хугацаа

Саналыг 2017 оны 2-р сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд “Монголын төмөр зам” ТӨХК-д албан бичгээр эсвэл baigalmaa@mtz.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хаяг:
“Монголын төмөр зам” Төрийн Өмчийн Хувьцаат Компани Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-23, УВН центр, 8-р давхар Улаанбаатар 14230
Утас: (976) 99140072
Факс: (976) 70106644
Вебсайт: www.mtz.mn

ЦАГ ҮЕ

ТОМИЛЛОЛ

Хамтын зүтгэлээр эх нутгаа хөгжүүлэх

СЭЛЭНГЭ АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН

2017 оны 1-р сарын 12, 13



Гэрэл зургийг Т.АРТУУЖИН

Төгсгөл. Түүрүүч нь I нүүрт

Түүнчлэн, зарим сумын зам, даваа хаагдах, алслагдсан сум багийн иргэд төрийн үйлчилгээг хүртэх боломжгүй болох нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээний техник хэрэгслийн судалгааг гаргах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд хүргэх эмч нарын багийг ажиллуулах, малчдад зориулсан сайн үйлсийн аяныг зохион байгуулах зэрэг арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэн ажиллаж байгаагаас гадна Хүдэр суманд гарсан бог малын цэцэг өвчнийг устгах, халдваргүйжүүлэх, хорио цээрийн дэглэм тогтоох, өвчилсөн малыг устгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймгийн Онцгой байдлын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, дээрх сумдын удирдлагууд, иргэд олон нийтийн хамтын хүчин чармайлтаар хэрэгжүүлэн ажиллаж байгаагаа дурьдлаа.

Сэлэнгэ аймаг энэ онд 145.5 мянган тонн байгалийн хадлан, 3299 тонн ногоон тэжээл, 10.7 мянган тонн хүчит тэжээл, 13.8 мянган тонн эрдэст тэжээл зэрэг хүрэлцэхүйц хэмжээний тэжээл бэлтгэжээ. Тэгвэл энэ талаар Ш.Оргил Засаг дарга хэлэхдээ, “Тариаланчдын маань бүтээл өндөр, ургац арвин байж, энэ онд 256.8 мянган тонн үр тариа, 42 мянган тонн төмс, 32.1 мянган тонн хүнсний ногоо хураан авсан амжилт үр дүнг бий болголоо. Эл амжилт үр дүнг урд жилийнхтэй харьцуулахад, үр тариа 90 гаруй мянган тонн буюу 60 гаруй хувиар, төмс, хүнсний ногоо 10.8–20.6 хувиар нэмэгдэж, улсын нийт хураан авсан үр тарианы 50 давсан хувийг аймаг дангаараа бэлтгэлээ” хэмээн баяртайгаар өгүүлсэн юм.

Шизуока мужтай газар тариалангийн салбарт хамтран ажиллахаар тохиролцожээ

Сэлэнгэ аймгийн ЗДТГ, ИТХ хамтран өнгөрсөн хугацаанд олон арван бүтээлч ажлыг хийж хэрэгжүүлж ирсэн. Тэр бүрийг энд дурьдах болбол бүтэн дугаарын зай талбай хүрэлцэхгүй байж мэднэ. Тиймээс Засаг дарга Ш.Оргилын илтгэлд дурьдагдсан хийж, хэрэгжүүлж, үр дүнг нь үзсэн ажлуудаас цухас дурьдаа. Төрийн захиргааны чиглэлээр, аймгийн гадаад харилцааг эдийн засагжуулах, үр нөлөөг дээшлүүлэх замаар уламжлалт харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэн шинэ түншлэлийг нэмэгдүүлэх зорилгыг дэвшүүлж, хэд хэдэн гэрээ хэлэлцээр, төсөл хөтөлбөрүүдийг баталгаажуулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлжээ.

Энэ хүрээнд Монгол Улсад суугаа Энэтхэг улсын элчин сайд, Кувейт улсын элчин сайд, АНУ-ын элчин сайдын яамны ерөнхий консулын албан ёсны айлчлалыг аймагтаа зохион байгуулж, АНУ-аас хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлох, Энэтхэг улсаас хөдөө аж ахуйн салбарт мэргэжилтэн бэлтгэх, Кувейт улсаас Сүхбаатар, Мандал сумдын Нэгдсэн эмнэлэгт иж бүрэн тоноглогдсон түргэний машин, тоног төхөөрөмж хандивлах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тохиролцсон байна. Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхий сайдын Япон улсад хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд тус улсын Шизуока мужтай газар тариалангийн салбарт хамтран ажиллахаар “Харилцан ойлголцлын санамж

бичиг”-т Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш. Оргил гарын үсэг зуржээ. Мөн Турк улсын хамтын ажиллагаа зохицуулах агентлаг (ТИКА)-тай хамтран ажиллах гэрээг байгуулж, Шаамар суманд “Зөгийн зорь барих”, аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт “Эрчимт эмчилгээний тасаг байгуулах” хэлэлцээрүүдийг баталгаажуулснаас гадна уламжлалт хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Буриад Улс, БНХАУ-ын ӨМӨЗО, БНСУ-д эрүүл мэнд, боловсролын салбарын мэргэжилтнүүдийг туршлага судлах арга хэмжээнд хамруулж, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн ЭТИС хөтөлбөрийн удирдлагуудыг хүлээн авч, цаашид хамтарч ажиллах салбар чиглэлээ тодорхойлжээ. Сэлэнгэ аймаг, БНХАУ-ын уул уурхайн “Жин Хуа” группийн хооронд, тус аймагт 50 мвт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцыг концессийн зарчмын дагуу хөрөнгө оруулан барьж байгуулах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан нь ч Сэлэнгэ аймгийн удирдлагын багийн онцлох ажлын нэг байлаа.

Тус станцыг барьж, ашиглалтад оруулснаар иргэд ая тухтай амьдрах нөхцөл боломжоор хангагдах юм. Мөн Баянгол сумын цэвэрлэх байгууламжид технологийн шинэчлэл хийх, үерийн усны хамгаалалтын далан байгуулах, Сант сумын төвийн цэвэр усны шугам шинэчлэх, цэвэрлэх байгууламж барих, Сайхан сумын гэр хорооллын айлуудыг цэвэр, бохир усны шугамтай болгох, Хөтөл хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, Сүхбаатар сумын дотор асфальт бетон, Баянгол сумын төвд хатуу хучилттай, Мандал сумын чиглэлд 31.2 км хатуу хучилттай авто зам тавих, Баянгол сумын халаалтын төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, сумын төвийн инженерийн шугам сүлжээг өргөтгөх зэрэг асуудлыг ч шийдвэрлэжээ. Хэдийгээр 2016 онд аймгийн төсөвт хүндэтгэй асуудал үүссэн ч, бүхий л нөөц бололцоог шавхан ажилласны дүнд багагүй ажлыг хийж гүйцэтгэсэн нь



дах аргагүй Сэлэнгэ аймгийн удирдлагын багийн амжилт юм. Тэгвэл зөвлөгөөнд тавьсан илтгэлийнхээ төгсгөл хэсэгт Засаг дарга Ш.Оргил “Хамтын зүтгэлээр эх нутгаа хөгжүүлэх” эрхэм зорилгын дор батлуулсан “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-өө танилцуулж, эцсийн дүндээ хамтын хүчин чармайлт, зүтгэлээр л дэвшүүлсэн хөтөлбөр нь биеллээ олж, үр дүнд нь сэлэнгэчүүд хожих учиртай онцлон тэмдэглэж байлаа. Аймгийн Засаг даргын илтгэлийн дараа агентлагийн дарга нар мэдээлэл хийсэн. Тэд аймгийнхаа хөгжил

дэвшил, хэрхэн ажиллах бодлого чиглэлээ тодорхойлж хүн нэг бүр болж, бүтэхгүй зүйл, асуудал бэрхшээлээ ярьж гарц, арга замаа эрэлхийлэв. Мөн аймгийн удирдлагын багийн бүрэлдэхүүн өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлын ололт амжилт, алдаа дутагдлаа дүгнэн, ирэх дөрвөн жилийн хөгжлийн зураг гаргасан нь гол үр дүн, ажлын биелэлт байлаа. Үүний дараа зөвлөгөөнд ирсэн төлөөлөгчид гурван хэсэгт хуваагдан салбар уулзалтыг зохион байгуулав. Мөн нөхөрсөг спортын тэмцээн ч зохион байгуулагдсанаар зөвлөгөөний эхний өдрийн үйл ажиллагаа дуусав.

Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө засахуйн учир

Харин зөвлөгөөний хоёр дахь өдрийн үйл ажиллагаа лекцээр эхэлсэн нь тун ч өвөрмөц байв. Тодруулбал, удирдагч хүн ямар байх ёстой, ажилтан албан хаагчдаа хэрхэн зүй зохистойгоор удирдан манлайлах талаар “Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас” гэх эртний мэргэдийн үгээр сэдэвлэсэн лекцийг Хувь хүний хөгжлийн хөрөнгө ТББ-ын тэргүүн Д.Мягмардорж нарын лекторууд уншсан нь зөвлөгөөнд ирсэн төлөөлөгчдийн сонирхлыг татаж байсан төдийгүй цаг үеэ олсон үйл ажиллагаа болж байсныг нуух юун. Тус лекцэд удирдагч хүн гэж хэнийг хэлэх вэ. Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө засахуйн учир. Сум орон нутгийн удирдагчид эхлээд хүнээ хөгжүүлж, улмаас тухайн хүнээр дамжуулан гэр бүл, цаашлаад сум хөгжих үндэснийг тавих учиртайг сануулсан халуун дулаан уур амьсгалтай лекц болсон.

Лекцийн дараа “Сэлэнгийн долгио” чуулгын уран бүтээлчдийн урлагийн тоглолт ч болж байлаа. Ийнхүү хоёр өдрийн турш 2016-2020 баримтлах бодлого чиглэл, цаашид анхаарах асуудлуудаа салбар бүрээр тодотгон харилцан мэдээллээ солилцсоны дараа 2017 онд хамтран ажиллах гэрээгээ баталгаажуулан, шинээр томилогдсон сумдын удирдлагууд энгэрийн тэмдэг, батламжаа гардан авлаа. Энэхүү ёслолын үйл ажиллагааны дараа Сэлэнгэ аймгийн засаг дарга Ш.Оргил сумдын засаг дарга, агентлагийн дарга, төрийн үйлчилгээний байгууллагын удирдлагууд, ойн ангийн дарга нарт үүрэг чиглэл өгөв. Тэрбээр “Сэлэнгэ аймгийн Засаг дарга миний бие бүрэн эрхийнхээ гарааны жилийг та бүхэнтэйгээ хамтдаа хэрэгжүүлэх олон зорилго, зорилттой, хүсэл эрмэлзлэл, итгэл дүүрэн ийнхүү эхлүүлж байна. Бүрэн эрхийн хугацааны төгсгөлд бид хийж хэрэгжүүлсэн ажлуулстэй, барьж байгуулсан бүтээн байгуулалттай, иргэд нь ажилтай орлоготой, хүүхэд залуус нь хөгжиж дэвшсэн, эдийн засаг нь чадавхижсан сайхан үр дүнгүүдийг иргэд тэмэндээ илтгэн гэж төсөөлж байна” хэмээгээд дараах үүрэг чиглэлийг өглөө.

M MINFO. Тал нутгийн цахим мэдээлэл

ЦАГ ҮЕ

СЭЛЭНГЭЧҮҮД ЗОРИЛТОО ТОДОРХОЙЛЛОО

Ш.Оргил: Иргэд үйлчлүүлэгчид ямар нэг байдлаар хүндрэл учруулахгүй хүлээн зөвшөөрөхгүй



нарийн баримталж ажиллах. Хэн хаашаа ямар ажлаар хэний зөвшөөрлөөр явсан, хэн гэдэг ямар албан тушаалтай хүн өөрийг чинь орлож байгааг зохих байгууллага, удирдлагуудад мэдээлж, зөвлөмж чиглэл авдаг байх. Цаг үеийн шуурхай уулзалт, хурал зөвлөгөөнийг би ямар ч төвшинд хэзээ ч зарлаж болно. Энэ бүхэнд бэлэн байх, зайлшгүй тохиолдолд хүн орлож ирүүлэх талаар урьдчилан мэдэгдэж байх. Цаг баримтлах асуудлыг анхдугаар зөвлөгөөнд дээрээ хатуу анхааруулж хэлбэ. Сэлэнгэ аймгийн ямар ч ажил, арга хэмжээ тогтсон цагтаа эхэлдэг, төлөвлөсөн цагтаа дуусдаг байх ёстой. Төрийн ажил албыг улс төрийн нөлөөллөөс ялгаж, салгадаг байх. Намчирхах, нутгархах үндэслэлээр төрийн албан хаагчдыг ялгаварлан гадуурхахгүй, намын харьяалал гэсэн ташуу үзлээр томилодог чөлөөлдөг асуудлыг энэ танхимд сууж байгаа хэн ч гаргахгүй гэж найдаж байна. Төрийн албан хаагчид аль 2009 онд намын харьяалалгүй болсон гэдгийг энд сануулж хэлбэ. Дунд шатны төрийн албан хаагчдыг бүх талаар чадваржуулахад онцгой анхаарах хэрэгтэй. Мэдлэг мэргэшил, харилцаа ёс зүйн хувьд тэднийг чадваржуулж байж дунд шатанд төрийн бодлого зорилт хэрэгжинэ гэдгийг ойлгох хэрэгтэй. Өнөөдөр та бидний байгуулсан үр дүнгийн гэрээ, хамтран ажиллах гэрээний үндсэн хэрэгжилтийг өөрийн биеэр харууцаж, хугацаанд нь биелэлтийг тайлагнадаг, хэрэгжүүлэх талаар санал санаачилга гаргаж ажиллаарай. Энэ гэрээ таны жилийн ажлын

...Хэрвээ миний тавьж байгаа шаардлага, баримталж буй зарчмыг мөрдөж ажиллахгүй бол би хамтарч ажиллах боломжгүй гэдгээ илэрхийлээд гаргасан шийдвэрийг өөрчилж болдог, байгуулсан гэрээг цуцалж болдог, шийдвэр гаргах эрх бүхий байгууллага албан тушаалтанд санал дэвшүүлж болдог гэдгийг дахин хатуу сануулья” хэмээсэн юм...

сахиж, зөрчил дутагдалгүй, төсвийн талаарх мэдлэг чадвараа дээшлүүлж, зарлагын уян хатан бодлого баримталж, өглөг авлага үүсгэхгүйгээр төсвийн хэмнэлтийн бодлого баримтлан ажиллах шаардлагатай байна. Энэ онд бидэнд бага зардлаар илүү их үр дүнд хүрэх амаргүй сорилт тулгарч байгаа. Төсвийн хэмнэлтийг бүх шатны удирдлагууд өөрсдөөсөө эхлэх ёстой. Хөрөнгө оруулалтын тухай асуудлыг 2017 оны батлагдсан төсвийн хүрээнд л хийнэ гэдгийг анхаарах хэрэгтэй” гэлээ. Мөн салбар тус бүрээр нь цаашид хэрхэн ажиллах талаар үүрэг чиглэл өгсөн юм. Тухайлбал, сумдын ИТХ, Засаг дарга нарын ажлын уялдаа холбоо орон нутгийн хөгжилд маш чухал учраас өөрсдийн эрх хэмжээ, нөөц бололцоогоо дайчлан асуудлыг дор бүр нь шийдвэрлэхийг хичээх хэрэгтэй. Өвөлжилт хүндэрсэн үед авах арга хэмжээ төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, тухайн үед ажиллах техник, хүн хүчний нөөцийг тооцож, бэлэн байдалд байлгах хэрэгтэй. ОНӨААТҮГ-ын удирдлагууд эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өр авлагыг барагдуулах талаар анхаарч, үйлдвэрийн газрын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах, сумдын ойн ангийн дарга нар бүс нутгийн хэмжээнд хүрч ажиллахыг үүрэгдэв. Энэ жилээс аймгийн Засаг дарга сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нартай гэрээ байгуулахаас бусад буюу гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнэх, хяналт тавих эрхээ хууль тогтоомжид нийцүүлэн сумдын Засаг дарга нарт шилжүүлж

байгаа юм байна. Эцэст нь, Засаг дарга Ш.Оргил удирдах ажилтны зөвлөгөөнд уригдсан албан тушаалтнуудад хандан “Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх шатны төрийн байгууллагуудад харилцаа хандлагын доголдол, хүнд суртлын талаар иргэдээс гомдол санал хүлээж авахгүй” гэдгийг анхааруулсны зэрэгцээ “Иргэд үйлчлүүлэгчид ямар нэг байдлаар хүндрэл учруулсан, зүй бусаар харилцсан ямар ч удирдлага, албан хаагчдыг аймгийн Засаг даргын хувнар би хүлээн зөвшөөрөхгүй. Сэлэнгэ аймагт төрийн үйлчилгээ нээлттэй, ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй, чирэгдэлгүй байх ёстой. Шийдвэр бол гарч болно, гэрээг ч байгуулж болно. Хэрвээ миний тавьж байгаа шаардлага, баримталж буй зарчмыг мөрдөж ажиллахгүй бол би хамтарч ажиллах боломжгүй гэдгээ илэрхийлээд гаргасан шийдвэрийг өөрчилж болдог, байгуулсан гэрээг цуцалж болдог, шийдвэр гаргах эрх бүхий байгууллага албан тушаалтанд санал дэвшүүлж болдог гэдгийг дахин хатуу сануулья” хэмээсэн юм. Ийнхүү үүрэг чиглэл өгснөөр “Хамтын зүтгэлээр эх нутгаа хөгжүүлбэ” гэх эрхэм зорилгынхоо үгээр удирдах ажилтны анхдугаар зөвлөгөөнд өндөрлөлөө. Хурлын завсарлагааны үеэр Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч Б.Нарантуяа, Боловсрол соёл урлагийн газрын дарга Ч.Жаргалсайхан нар болон сумдын Засаг дарга нартай уулзан зарим зүйлийг тодруулсан юм.

/Сэлэнгэ аймгийн засаг дарга/

“Аймгийн удирдлагын баг бүрэн бүрэлдэхүүнээрээ цуглаж, зорилго зорилтоо тодотгохын сацуу төрийн ажил үйлчилгээг иргэдэд хүргэх, аймаг, орон нутаг, салбарын хөгжлөөрөө улсдаа түүчээлэхэд цаашид юун дээр анхаарах талаар анхны уулзалтаараа хэлэлцэж, аймгийн Засаг даргын зүгээс энэ дөрвөн жилийн хугацаанд ямар зарчим баримталж, ямар шаардлага тавьж ажиллахаа та наргаа хэлэх нь зүйтэй гэж бодож байна. Юуны өмнө Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж байгаа бол аймаг, орон нутагтайгаа

ажлын уялдаа холбоотой байж аймгийн ИТХ, Засаг дарга, түүний ажлын албатай хамтарч ажиллах хэрэгтэйг сануулъя. Төрийн ажил цаасан дээр явдаг. Бид хийж хэрэгжүүлсэн ажил арга хэмжээгээ дээд шатны байгууллагадаа тайлагнах, мэдээлэх, иргэд олон нийтэд хүргэж байх үүрэгтэй. Иймд тайлан мэдээ, албан бичиг тоотын хариуг үнэн зөв баримт, судалгаа тооцоог үндэслэн хугацаанд нь өөрийн биеэр харууцагатайгаар хянан баталгаажуулж холбогдох байгууллагад хүргүүлдэг байх. Төрийн албаны захирах захирагдах ёсыг үйл ажиллагаандаа



Б.Нарантуяа: Цаашдын зорилгоо тодорхойлж чадлаа

/Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч/

Сэлэнгэ аймгийн ЗДТ-аас Удирдах ажилтны зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулдаг. Энэ удаагийн Удирдах ажилтны зөвлөгөөн оны эхэнд болж буйгаараа онцлог. “Хамтын зүтгэлээр эх нутгаа хөгжүүлбэ” эрхэм зорилгын дор аймгийн ИТХ-аас батлуулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарааны анхдугаар зөвлөгөөнд 17 сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нар, орон нутгийн өмчит газрын

дарга, захирлууд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, аймгийнхаа хөгжил дэвшлийнхээ ерөнхий дүр зургийг гаргаж, 2017 онд хэрхэн ажиллах бодлого чиглэлээ тодорхойлсны сацуу зөвлөгөөнд оролцож буй хүн нэг бүр асуудал бэрхшээлээ ярьж гарц, арга замаа эрэлхийлсэн нь хамгийн том үр дүн байлаа. Мөн төрийн ажил үйлчилгээг иргэдэд хүргэх цаашлаад аймаг, орон нутаг хөгжлөөрөө улсдаа түүчээлэхэд юунд анхаарах, Засаг даргын зүгээс ямар зарчим, бодлого баримтлах, ямар шаардлага тавьж

ажиллах зэргээр харилцан ярилцаж, харилцан туршлага судалсан гэж дүгнэж болно. Түүнчлэн аймгийн Засаг дарга энэ онд хамтран ажиллах гэрээгээ удирдлагын багтай баталгаажуулсан. Удирдах албан тушаалд анх удаагаа томилогдсон дарга нар олон байгаа учраас удирдах арга барил, ажилдаа ямар хэм хэмжээг баримтлавал үр дүнд хүрэх талаархи лекцийг ч зохион байгуулсан. Ямартай ч, дэвшүүлсэн зорилгоо хүрч чадсан үйл ажиллагаа болж чадлаа.



Ч.Жаргалсайхан: Удирдах ажилтнуудад зориулсан лекц зохион байгуулснаараа онцлог болсон

захирал, цэцэрлэгийн эрхлэгчдийг хамруулан өргөн бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан нь туйлын ач холбогдолтой болсон гэдгийг юун түрүүнд хэлэх хэрэгтэй болов уу. Зөвлөгөөнөөр 2017 он хийгээд Сэлэнгэ аймгийн хэмжээнд цаашид баримтлах бодлого, чиглэлийн талаар Засаг дарга Ш.Оргил нийт удирдах ажилтнуудад мэдээлэл өгч, үр дүнгийн гэрээ байгуулсан. Түүнчлэн, зөвлөгөөний үеэр сургууль, цэцэрлэгийн эрхлэгчид ч цаашдын чиглэл, хүндрэл бэрхшээл, түүнийг даван

туулах шийдэл, арга замын талаар ярилцан санал солилцож, нэг нэгээсээ харилцан суралцаж, туршлага солилцоо. Сэлэнгэ аймгийн Улсын тэргүүний IV дүгээр сургууль дээр сургуулийн захирлууд очиж, үйл ажиллагаатай нь танилцан туршлага судалсан бол цэцэрлэгийн эрхлэгчид IV цэцэрлэгт ажилласан. IV цэцэрлэг саяхан шинэ өргөтгөлийн барилгаа ашиглалтад хүлээн авсан. Энэ өргөтгөлийг канад технологиор барьж ашиглалтад оруулсан

юм. Өргөтгөлийг хүлээн авснаас хойшхи ахархан хугацаанд цэцэрлэгийг хэрхэн тохижуулсан хийгээд тус цэцэрлэгийн хамт олон хүүхэдтэйгээ хэрхэн ажиллаж, эцэг эхчүүдтэй яаж харилцдаг талаар мөн туршлага судаллаа. Түүнчлэн, Аймгийн ЗДТ-аас зохион байгуулсан Удирдах ажилтны анхдугаар зөвлөгөөний хөтөлбөрт тусгагдсан нэг онцлох үйл ажиллагаа нь удирдах ажилтнуудад зориулсан лекц байлаа. Орон нутгийн хөгжилд бие хүн, удирдагч хүн

хэрхэн манлайлан оролцох талаархи лекцийг Хувь хүний хөгжлийн хөрөнгө ТББ-ын тэргүүн Д.Мягмардорж уншлаа. Миний хувьд энэ үйл ажиллагааг цаг үеэ олсон, чухал ач холбогдолтой арга хэмжээ гэж дүгнэж байгаа. Учир нь шинээр томилогдсон сум, ИТХ, агентлаг, сургууль, цэцэрлэгийн дарга нар олон бий. Тэдгээр хүмүүс цаашдаа яаж удирдан манлайлах, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ хэрхэн оруулах, өөрийгөө хөгжүүлэх талаар үнэтэй зөвлөгөө сонссон гэдэгт итгэлтэй байна.

/Боловсрол, соёл урлагийн газрын дарга/

Энэ удаагийн Сэлэнгэ аймгийн удирдах ажилтны зөвлөгөөн урьд жилүүдээс ихээхэн онцлогтой болж

өндөрлөлөө. Аймгийн ЗДТ-аас зохион байгуулсан гарааны жилийн анхдугаар удирдах ажилтны зөвлөгөөнд сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, агентлагийн дарга нараас гадна сургуулийн

Ц.Отгонтүйн: Хүний хөгжлийг голлоно

/Түшиг сумын Засаг дарга/

Манай нутагт сайхан өвөл болж байна. Өмнөх жилүүдийг бодоход цас их унасан ч, өвөлжилт сайн байгаа. Түшиг сум бусад сумыг бодвол хамгийн бага малтай. Өнгөрсөн оны тооллогоор 5000 гаруй мал тоологдсон нь өссөн үзүүлэлт. Төсвийн хувьд хүндэрсэн зүйлгүй. Энэ онд аль болох үргүй зардал гаргахгүй байх тал дээр менежерүүдтэйгээ ярьж тохиролцоод оны эхний ажлыг эхлүүллээ. Өмнөх дөрвөн жилд нийгмийн салбарынхаа хөрөнгө оруулалтыг сайн хийсэн. Аймаг, орон нутгийн зүгээс ч дэмжлэг үзүүлсэн. Харин

ирэх дөрвөн жилд өрх бүрийнхээ орлогыг нэмэгдүүлсэн, амьдралыг дээшлүүлсэн дорвитой ажлыг хийж хэрэгжүүлнэ гэсэн зорилго тавьж байгаа. Хүн нийгмийн хөдөлгөгч хүч гэдэг утгаараа хүний хөгжлийг голлоно. Материаллаг хөгжил гэхээсээ илүүтэйгээр иргэдийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх эдийн засгийг бий болгохоор төлөвлөсөн. Монголчууд сүүлийн жилүүдэд баялаг бүтээдэг болсон. Гагцхүү тэдний хийсэн бүтээгдэхүүнийг ямар оновчтой сувгаар борлуулах вэ гэдэг асуудал л тулгамдаж байгаа. Үүнийг шийдчихвэл нийгэмд тулгарсан ажилгүйдэл, ядуурал

шийдэгдэнэ гэж харж байна. Ганцаараа гэхээсээ илүүтэй бүсийн хэмжээнд зохион байгуулах нь илүү үр дүнтэй шүү дээ. Аймгийн хэмжээний нүүрсний уурхай манайд байдаг ч тогтвортой ажилладаггүй. Уурхай ажилласнаар зөвхөн манай сумаас 112 хүн ажлын байраар хангагдах учиртай. Ирэх дөрвөн жилд уул уурхай гэхээсээ илүүтэйгээр экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг илүүтэй баримтлаж гэж байгаа. Шаамараас зөгий үржүүлгийн хөтөлбөр боловсруулж байна. Үүнийг дагаад аж ахуй нэгж, өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Хүний хөгжлийг голлоно. Материаллаг хөгжил гэхээсээ илүүтэйгээр иргэдийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх эдийн засгийг бий болгохоор төлөвлөсөн. Монголчууд сүүлийн жилүүдэд баялаг бүтээдэг болсон. Гагцхүү тэдний хийсэн бүтээгдэхүүнийг ямар оновчтой сувгаар борлуулах вэ гэдэг асуудал л тулгамдаж байгаа. Үүнийг шийдчихвэл нийгэмд тулгарсан ажилгүйдэл, ядуурал



ЖУДО БӨХИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН УАШТ

М.УРАНЦЭЦЭГ, Д.СУМЪЯА НАР ЗАНГАРГАА ХАРУУЛЖ, ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨНГӨН ЖИНД ШИНЭ АВАРГУУД ТӨРЛӨӨ

**Эрэгтэй****60 кг**

- 1 Ж.Амарболд /Сүлд спорт хороо/
- 2 Мягмардорж /Сүлд спорт хороо/
- 3 Б.Амартүвшин /Женко клуб/
- 4 Д.Амартүвшин

66 кг

- 1 Г.Хэрлэн /Сүлд спорт хороо/
- 2 Б.Эрхэмбаяр /Увс нуур дэвжээ/
- 3 Д.Алтансүх /Хангарьд спорт хороо/
- 4 Н.Ганболд /Женко/

73 кг

- 1 Г.Одбаяр /Женко клуб/
- 2 С.Баяртүвшин /Увс нуур клуб/
- 3 Ц.Цогтбаатар /Сүлд спорт хороо/
- 4 Н.Хадбаатар /Хилчин спорт хороо/

Эмэгтэй**48 кг**

- 1 М.Уранцэцэг
- 2 Э.Базаррагчаа /Женко клуб/
- 3 Э.Уртнасан /Хилчин спорт хороо/
- 4 Ж.Чандалдулам /Аврагч спорт хороо/

52 кг

- 1 Б.Бат-Эрдэнэ /Монголын жудо академ/
- 2 Б.Хорлоодой /Хилчин спорт хороо/
- 3 Сосорбарам /Монголын жудо академ/
- 4 П.Буянхишиг /Женко клуб/

57 кг

- 1 Д.Сумъяа
- 2 А.Цолмон /Алдар спорт хороо/
- 3 Т.Мөнгөнтуяа /Монголын жудо академ/
- 4 Н.Отгонцэцэг /Тэмүүжин клуб/

Н.ПУНЦАГБОЛД

Жудо бөхийн 2017 оны Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээн өчигдөр Спортын төв ордны "А" зааланд эхэллээ. Энэ удаагийн улсын аваргад 300 гаруй жудоч оролцож байгаа юм. Тиймдээ ч жин тус бүрт маш олон тамирчин оролцож, тэр хэрээрээ өрсөлдөөнтэй боллоо. Тэмцээний эхний өдөр эрэгтэй 60, 66, 73, эмэгтэй 48, 52, 57, 63 кг-ын жингийн барилдаанууд болж, аваргаа тодруулсан юм. Улсын аваргад шинэ залуу тамирчид хүч түрэн гарч ирж, шилгүүд эрт өвдөг шороодсон гэдгээрээ онцлогтой байлаа. Тэр дундаа эрэгтэйчүүдийн хөнгөн жин болох 60, 66 кг-д шинэ аваргууд төрлөө.

Тухайлбал, 60 кг-ын жинд дэлхийн хэмжээний тамирчдаас ганцхан Д.Амартүвшин л зодогдсон. Дэлхийн аварга Г.Болдбаатар, ОУХМ Г.Хэрлэн, өнгөрсөн жилийн улсын аварга Ц.Цогтбаатар нар жин өгсч барилдсан юм. Тиймдээ ч Д.Амартүвшинд түрүүлэх боломж маш өндөр байсан. Харамсалтай нь тэрбээр ердөө л хүрэл медаль дээр буулаа. Энэ жинд Ж.Амарболд түрүүлж, шинэ залуу шилдэг жудоч гарч ирж буйг харууллаа. 66 кг-д шилдэг бөхчүүд чихэлдсэн. Энэ жингийн шилдэг бөх Д.Төмөрхүлэгээс авахуулаад А.Батсуурь, Д.Алтансүх, жин өгсч орж ирсэн Г.Хэрлэн, Г.Болдбаатар гэх мэт манай улсын шилдэг тамирчид өрсөлдсөн. Тэр утгаараа шуугиан дүүрэн барилдаанууд боллоо. Тухайлбал, ОУХМ Д.Төмөрхүлэг эхний тойрогтоо ялагдсан нь энэ удаагийн улсын аваргын хамгийн том дуулиан байв. Түүнээс гадна А.Батсуурь, Г.Болдбаатар



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

тэргүүтэй шилдгүүд медальгүй хоцорсон юм. Харин Г.Хэрлэн жин өгсч барилдаад түрүүлээ. Ингэснээр 60, 66 кг-д улсын аварга болсон бөх болов. Энэ жинд Б.Эрхэмбаяр хэмээх залуу тамирчин гарч ирж, мөнгөн медаль хүртсэн бол 73 кг-ын тухайд Г.Одбаяр зангарга заалаа. Тэгвэл эмэгтэйчүүдийн тухайд дуулиан шуугиантай барилдаан болсонгүй. 48 кг-д М.Уранцэцэг, 52-т Б.Бат-Эрдэнэ, 57 кг-д Д.Сумъяа, 63-т Б.Ганхайч

нар түрүүлэв. Өнгөрсөн жилийн улсын аварга болсон бөхчүүд амжилтаа бататгаж, зангаргаа харуулсан. 48 кг-д өнгөрсөн жил М.Уранцэцэг барилдаагүй учраас Э.Базаррагчаа түрүүлсэн юм. Харин энэ жил тэрбээр барилдсан, харин Э.Базаррагчаа ямархуу энтэй бөх болохоо харуулж дахин финалд гарсан юм.

ДУУЛГАХ СОНИН

"Миний найз бүсгүйчүүд" цомгийн баяр болно




"Хоёулаа хамт жаргалтай явна" хэмээх хит дуугаараа олны сонорыг мялаасан хөгжмийн зохиолч О.Эрдэнэ "Миний найз бүсгүйчүүд" цомгоо саяхан өлгийдөж авчээ. Тэрбээр өмнө нь "Тангараа", "Хоёулаа хамт жаргалтай явна", "Нандин" зэрэг цомгууд гаргаж байсан ч цомгийн баяр огт хийж байгаагүй гэнэ. Харин энэ удаад цомгийн баяраа энэ сарын 21-ний өдөр буюу бямба гарагт "Хүннү Молл" их дэлгүүрт хийхээр төлөвлөжээ. Тэрбээр хамгийн эхэнд ирсэн 30 хүнд шинэ цомгоо бэлэглэхээс гадна, янз бүрийн хөгжилтэй тэмцээн зохион байгуулахаас гадна ирсэн үзэгчдээс хоёр аэтан тодруулж, Байгаль нуур болон Манжуур хотод аялах аяллын эрхээр шагнаж юм байна.

А.Баярцэцэг ирэх сард ирнэ

АНУ-ын Вашингтон хотноо болсон 66 дахь удаагийн "Дэлхийн мисс"-т амжилттай оролцож, шилдэг 11 оролцогчийн нэг болсон мисс А.Баярцэцэг ирэх сард Монголд ирэх гэнэ. Түүний хувьд "Дэлхийн мисс" тэмцээн өндөрлөсний дараа хувийн ажлаа амжуулахаар үлдсэн

юм. Харин мисс А.Баярцэцэгийн дүр бүтээсэн "Явуулын хүн" уран сайхны кино тун удахгүй нээлтээ хийх аж. "Mongolian Social Channel" студийн бүтээл тус киноны Ариунаа гэх хөдөөний эгэл жирийн бүсгүйн дүрд тэрбээр тогложээ. Тус киноны гол дүрүүдэд Гавьяат жүжигчин

С.Дамдин, Ё.Цог, Л.Дэмидбаатар нарын уран бүтээлч тоглосноос гадна Ерөнхий найруулагчаар Д.Баярсайхан ажиллажээ. "Явуулын хүн" уран сайхны киноны зураг авалтыг өнгөрөгч есдүгээр сард Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт авсан байна.



Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -22
Шөнө -30

Нөгөөдөр
Өдөр -19
Шөнө -31

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ДУНД ИЛҮҮ ЦАГААН ХУЛГАНА САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХӨХ ЛҮҮ ӨДӨР

Наран ургах шингэх: 08.36-17.29

Үс засуулбал: Өлсөж ундаасна



Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг луу нөлөөтэй тул элдэв үйлд хяналтай хандаж, биеэ энхрийлүүштэй. Буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амилуулах, дэлгэрүүлэх, эрхлэх үйл нигүүд бүтээх, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголттой үг сонсох, таснай заагтнавал гэр аридах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал голдол аюул болох болой. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.

Бидэнд тохиолдсон

КҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Ц.Лхачинбат

Өглөө таксинд суув. "9:00 цагаас сургалттай учир яаруухан явна шүү ах" гэсэн "Ох" л гэж байна... Тэгснээ заасан зүгээс тойроод жийж байна шүү... Тэрүүгээр явбал уг нь ойрхондоо гэсэн чинь ах "Би мэдэж байна" л гэнэ. Явж байгаад сая баруун эргэвэл уг нь ойрхондоо гэлээ ах "Би мэдэж байна" л гэнэ... би дуугуй явсаар байгаад ирэх газраа ирлээ. Ах 3000 өгөөрэй гэхээр 1500 өгөөд "Би мэдэж байна" гээд бууцхсан хэхэ...Өдөржингөө бодогдоод

Хорбоо Барин: Японь Шүчин самидын нам /Соёл мэдээллийн хэлтэс/ 970777

10 ДАХЬ УДААГИЙН ЯПОН КИНОНЫ 2017 ОН ӨДРҮҮД

2017 оны 01 сарын 18-20-ныг хүртэл өдөр бүр 15:00, 18:00 цагуудаас Тэнгис кино театрт ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ

Зохион байгуулагч: